Тарагт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
2025 оны ..... дугаар сарын .... өдрийн
.........дугаар тогтоолын хавсралт

# ТАРАГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Нийт хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хэрэгжилттийн явц | Хэрэгжилтийн хувь | ИТХ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ.СУМЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| **1.1 ДЭД БҮТЭЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ** | | | | | | | | |
| 1 | 1.1.1. Арвайхээр-Тарагт чиглэлийн 30 км авто замыг нутгийн зам төслийн хүрээнд барьж эхлүүлнэ. | ЗДТГ | Улсын төсөв 380,0 | Авто зам тавигдсан байдалд үндэслэнэ. | Арвайхээрээс Тарагт сум хүртэл шороон замтай. | Арвайхээр-Тарагт-Уянга чиглэлийн авто замын зураг төсөв нь хийгдсэн. | 100 | 100 |
| 2 | 1.1.2. Сумын төвийн инженерийн шугам сүлжээний зураг төслийг боловсруулж, ажлыг эхлүүлнэ | ЗДТГ | Улсын төсөв | Инженерийн шугам шүлжээний зураг,ажлын явцаар | Сумын төвийн төрийн байгууллагуудруу халаалтын шугам тавигдсан. | Хугацаа болоогүй | - | - |
| 3 | 1.1.3.Сумын үйлдвэржилтийн бүсэд цахилгааны шугам сүлжээний өргөтгөл хийх | ЗДТГ | Улсын төсөв | Зураг төсөв хийгдсэн байдлаар | - | Хугацаа болоогүй | - | - |
| 4 | 1.1.4. Сумын төвийн хатуу хучилттай зам дагуу явган хүний зам | ЗДТГ | | Засвар хийсэн,шинээр нэмэгдүүлсэн | Төв зам дугуу шинээр 8 | Төв зам дагуу 6 гэрлийг засварласан. Засмал замын хагарсан хэсгүүдэд нөхөөс хийсэн. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тавьж, гэрэлтүүлгийг өргөтгөн, засвар, арчлалт хийж, тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу хийнэ. | | Орон нутгийн төсөв | ажлын үр дүнгээр | гэрэлтүүлэг тавигдсан. | | | |
| 5 | 1.1.5. Улсын чанартай хэвтээ, босоо чиглэлийн зам дагуу, зарим багийн төвүүдийг сайжруулсан замаар холбох ажлыг эхлүүлэх | ЗДТГ | Улсын төсөв | Сумын ерөнхий төлөвлөгөөний зураг төсөвт үндэслэнэ. | 0 | Хугацаа болоогүй | - | - |
| **Хэсгийн дундаж үнэлгээ:100**<br>**Хэсгийн дундаж үнэлгээ: 100** | | | | | | | | |
| **1.2. ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР ХӨГЖҮҮЛЭХ** | | | | | | | | |
| **1.2.1. Хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр хөгжүүлнэ.** | | | | | | | | |
| 6 | 1..2.1.1.Сумын хэсэгчилсэн төлөвлөгөөний зураг төсвийг батлуулах | ЗДТГ | ОНХСан 12,0 | Шинээр эрхэлж буй ХАА үйлдвэрлэлийн тоогоор | - | Үйлдвэржилтийн хэсэгчилсэн төлөвлөгөөний зураг төсвийг орон нутгийн хөгжлийн сангийн 12,0 сая төгрөгийн санхүүжилтээр Баянгол прожект ХХК-аар гүйцэтгүүлсэн. | 100 | 100 |
| 7 | 1.2.1.2. Уламжлалт мал аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэх, анхан шатны боловсруулалт хийх аж ахуйг дэмжинэ . | ЗДТГ | Улсын төсөв-480,0, Орон нутгийн төсөв-5,5 | Боловсруулалт хийж байгаа иргэний тоо | Арьс, шир, сур суран эдлэл, сархинагаар өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 5 иргэн байна. | Сүүний чиглэлийн үхэр худалдан авах 6 иргэний төсөлд 480.0 сая төгрөгийн зээлийг Төрийн болон ХААН банкаар дамжуулан олгогдсон байна. Орон нутгийн хөгжлийн сангийн 5,5 сая төгрөгийн санхүүжилтээр сур элдэх төхөөрөмжийг худалдан авч үйл ажиллагааг явуулахад бэлтгэж байна. | 100 | 100 |
| 8 | 1.2.1.3. Цэвэр усны үйлдвэр, хоёрдогч түүхий эд | ЗДТГ | | Үйлдвэрлэл барьж байгуулахад | 2023 онд Орон нутгийн хөгжлийн сангаас малчдад | Хугацаа болоогүй | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулах цехийг байгуулахад дэмжиж ажиллана. | | | дэмжсэн дэмжлэгийн хувиар | үрийн дэмжлэг үзүүлсэн. | | | |
| 9 | 1.2.1.4. Малын тэжээл тариалалтыг дэмжиж ажиллана. | ЗДТГ | ААН, иргэн | Тариалалт хийсэн талбай га аар | ОНХСангаас 12,5 сая төгрөгийн малын тэжээлийн үрийн дэмжлэг олгосон. | ААН, иргэд 18 га-д тариалалт хийж 14 тн малын тэжээл хураан авсан. | 100 | 70 |
| **Хэсгийн дундаж үнэлгээ:100 %**<br>**Хэсгийн дундаж үнэлгээ: 90%** | | | | | | | | |
| **Хоёр. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| **2.1. ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ, ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ** | | | | | | | | |
| 10 | 2.1.1.1. Хүүхдийн хөгжлийн онцлог, суралцах чадамжид суурилсан уян хатан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг хэрэгжүүлнэ. | ЕБС | - | Гүйцэтгэлийн үр дүнгээр | ЕБС 2024 оны гүйцэтгэлийн үнэлгээнд 14 багш хамрагдаж байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ 76,6%-тай үнэлэгдсэн.<br>7 багш II-IV-р түвшинд үнэлэгдэж урамшуулал авсан. | Ерөнхий боловсролын сургууль 2023-2024 оны хичээлийн жилд гүйцэтгэлийн үнэлгээнд нийт 14 багш давхардсан тоогоор 272 суралцагч хамрагдаж байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ 76.6 үнэлэгдэж өмнөх оноос 6 хувиар үнэлгээгээ ахиулсан. Нийт багш нарын 50 хувь нь буюу 7 багш II-IV түвшинд үнэлэгдэж 15-25 хувийн урамшуулал авах болзол шаардлагыг хангасан. ЕБС 2024-2025 оны хичээлийн жилд гүйцэтгэлийн үнэлгээнд нийт 16 багш, давхардсан тоогоор 265 суралцагч хамрагдаж байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ 77.7 үнэлэгдэж өмнөх оноос 1.1 хувиар үнэлгээгээ ахиулсан. Нийт багш нарын 0.6 хувь нь буюу 1 багш IV түвшинд үнэлэгдэж 15 хувийн урамшуулал авах болзол шаардлагыг хангасан.<br>СӨББ-ын сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд: Бэлтгэл бүлгийн мэргэжлийн хөгжлийн бүлгээр шинэчилсэн хөтөлбөр хэрэгжүүлэн 1 улирал, 2 | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар, 3 улирал хамтран боловсруулан шар өнгө: Өдрийн дэглэм дагуу уялдуулан өглөөний хүлээн авалт, өглөөний дасгал, тойргийн цаг, хоололт, чиглүүлэгтэй тоглоом, чөлөөт тоглоом, зугаалгын цаг, номын цаг, нойрсолт, эрүүл ахуйн цаг, хөдөлгөөнт тоглоом, хөгжөөн баясгах цаг, таралт, сургалт үйл ажиллагааны төлөвлөлт тусган, мөн нэмэлтээр асуулт, дэмжлэг, ажиглалт, эргэцүүлэмж, төлөвлөгөө, төлөвлөлтийг боловсруулан хянуулж, хэрэгжүүлэн ажилласан. | | |
| 11 | 2.1.1.2 Ерөнхий боловсролын сургуулийн 3-5 дугаар ангид англи хэлний Pearson, математикийн Eduten хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суралцагсдад кодчилол, роботик болон хиймэл оюуны ур чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ. | ЕБС | - | Хөтөлбөрийн үр дүнгээр | Ерөнхий боловсролын сургуулийн 5-6 дугаар ангид англи хэлний Pearson, 1-5-р ангид математикийн Eduten хөтөлбөрийг хэрэгжүүлсэн Хөтөлбөрийн хэрэгжилт 2023-2024 оны хичээлийн жилд EDUTEN-69% PEARSON -56% байсан.<br>Бага боловсролын хүрээнд сурагчдын техник сэтгэлгээг хөгжүүлэх, STEM загвар угсрах сургалт зохион байгуулагддаг | **PEARSON хөтөлбөрийн хэрэгжилт:**<br>2024-2025 оны хичээлийн жилд Бага боловсролын хүрээнд PEARSON хөтөтөлбөрт 5-р ангийн 1 бүлгийн 25 сурагч хамрагдаж байгаа бөгөөд хэрэгжилт 74%, суурь боловсролын хүрээнд PEARSON хөтөлбөр 6,7-р ангийн 2 бүлгийн 38 сурагч хамрагдаж хэрэгжилт 6-р анги -70%, 7-р анги – 78%, дундаж гүйцэтгэл 74% -тай тус тус үнэлэгдсэн.<br>2025-2026 оны хичээлийн жилд Бага боловсролын хүрээнд PEARSON хөтөтөлбөрт 3-5--р ангийн 3 бүлгийн 57 сурагч хамрагдаж хэрэгжилтийн хувь – **43,2%,** суурь боловсролын хүрээнд PEARSON хөтөлбөр 6,7,8-р ангийн 3 бүлгийн 59 сурагч хамрагдаж хэрэгжилт 6-р анги -26,4%, 7-р анги – 38,6%, 8-р анги 56% дундаж гүйцэтгэл **40,3%** -тай үнэлэгдлээ. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **EDUTEN хөтөлбөрийн хэрэгжилт:** 2024-2025 оны хичээлийн жилд 1-5-р ангийн нийт 5 бүлгийн 104 сурагч EDUTEN хөтөлбөрт хамрагдсан. Хөтөлбөрийн хэрэгжилт сургуулийн дундаж гүйцэтгэл **82%,**<br><br>2025-2026 оны хичээлийн жилд EDUTEN хөтөлбөртбага боловсролын түвшинд 1-5-р ангийн 87 сурагч суурь боловсролын түвшинд 6-р ангийн 22 сурагч хамрагдаж байна. Хөтөлбөрийн хэрэгжилт сургуулийн дундаж гүйцэтгэл **84%,**<br><br>Бага боловсролын хүрээнд Бие даалтын 7 хоногийн үйл ажиллагаанд сурагчдын техник сэтгэлгээг хөгжүүлэх STEM сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт 2-5-р ангийн 68 сурагч хамрагдсан. Мөн сурагчдын дунд “Бүтээлч багачууд” STEM загар угсрах уралдааныг зохион байгуулсан. Уралдаанд 2-5-р ангийн 20 груй сурагч оролцсон байна | | |
| 12 | 2.1.2.3. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж, удирдлага болон багш солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | ЕБС, СӨББ | | Багш солилцооны хөтөлбөрт хамрагдсан багшийн тоогоор | 2024 онд 4 багшийг багш солилцооны хөтөлбөрт хамруулсан. | Эрхлэгч Б.Батдолгор “Хангайн“ бүсийн, эрхлэгч арга зүйч нарын дунд зохион байгууллагдсан “ХАМТДАА ХӨГЖЬЕ” гэсэн нэртэй уулзалтанд туршлага судлаж, тэр сургалтаараа байгууллагын багш ажилчдын дунд эерэг бүхнээр өөрсдийгөө цэнэглэе уриатай<br>“ТАЛАРХЛЫН ИЛГЭЭМЖ”-2 сарын аянг хэрэгжүүлэн ажилласан.<br>Мөн “Шинэчилсэн“ хөтөлбөрийн хүрээнд 9 дүгээр цэцэрлэгийн арга | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зүйч А.Туяа, 11 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Б.Болормаа нар ирж багш нарын нэг өдрийн сургалт үйл ажиллагаанд сууж зөвөлгөө өгч хамтран ажилласан.<br><br>**ЕБС-ийн хувьд:**<br><br>2025-2026 оны хичээлийн жилд бага боловсролын хүрээнд Арвайхээр сумын 2 дугаар сургуультай хамтран туршлага судлах үйл ажиллагааг зохион байгуулж бага ангийн 3 багш бага боловсролын сургалтын менежер нийт 4 багш, ажилтан багш солилцоо хөтөлбөрт хамрагдлаа. Бага ангийн багш нар 2 дугаар сургуулийн тэргүүлэх зэрэгтэй шилдэг багш нарын хичээл төлөвлөлт, даалгавар боловсруулалт, МХБ-ийн үйл ажиллагаатай танилцаж, сурагчидтай ажиллах арга зүйгээс суралцсан. \ биелэлт - 100%\ | | |
| **2.2.Боловсролын бүх шатанд хүүхдийн хөгжил, хамгааллын орчинг сайжруулж, хүүхдийн сурч, хөгжих тэгш эрхийг хангана.** | | | | | | | | |
| 13 | 2.2.1.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт “Сүү хөтөлбөрт” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | ЕБС,СӨББ | | Хөтөлбөр хэрэгжилтийн үр дүнгээр | 2024 онд “Сүү” хөтөлбөрийг ЕБС, СӨББ-ийн хүүхдүүдэд байгууллагын төсвөөр 30 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлсэн. | Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Сүү хөтөлбөр”-ийн хүрээнд ажлын 7 хоногийн 3 өдөр байгууллагаас сүү өгч, 2 өдрийн сүүг эцэг эхчүүдтэйгээ гэрээ байгуулан өгч байна. Сүүний ашиг тусын талаар эцэг эхчүүдэд тогооч нар сургалт явуулж гарын авлага брошур хийн тараасан. Сүүг өгснөөр хүүхэд бүрийн өсөлт хөгжлийг дэмжин кальци | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Улсын болон иргэн, ААН төсөв | | | дутагдлаас урьдчилан сэргийлж, ой тогтоолт сайжирч байна.<br>Хүүхдийн хоол хүнсийг шинэжилгээнд бүрэн хамруулан эрүүл ахуйн шаардлага хангасан шим тэжээлтэй олон нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр хангаж үйлчилж байна.<br>**ЕБС – ийн хувьд:**<br>2025 оны хичээлийн жилийн 3-р улиралд буюу 2025 оны 5 сараас бага ангийн 5 бүлэг , дунд ахлах ангийн 5 бүлэгт **“Сүү хөтөлбөр**”- ийг туршин хэрэгжүүлсэн. Дунд болон ахлах ангийн 5 бүлэгт эцэг эхийн дэмжлэгтэйгээр **25** өдөр **3.100.000** төгрөгний санхүүжилтээр **69** сурагчийг хамруулан тетрапак савлагаатай сүү болон таргаар үйлчилсэн байна.<br>2025-2026 оны хичээлийн жил буюу 2025 оны 9 сараас бага боловсролын хүрээнд “Үдийн хоол” хөтөлбөрөөр дамжуулан 7 хоногт 3 өдөр сүү, сүүн бүтээгдэхүүн, дотуур байранд долоо хоногт 3-4 өдөр сүү, сүүн бүтээгдэхүүнээр тус тус үйлчилж “**Сүү хөтөлбөр**”-ийг хэрэгжүүллээ.<br>Суурь болон бүрэн дунд боловсролын хүрээнд 6-12-р ангийн 7 бүлэгт эцэг эхийн оролцоотойгоор “ Өдөр бүр нэг аяга сүү” үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан. **Зарцуулсан зардал:**<br>➢ Үдийн хоол хөтөлбөрөөс – 2,350,000 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ➢ Дотуур байр хоолны зардлаас – 2,500,000<br>➢ Эцэг эхийн оролцоотой – 8,270,000 орчим<br>Нийт зардал – 13, 120,000 орчим зардлыг зарцуулсан байна. | | |
| 14 | 2.2.2. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцүүлэн, хувилбарт сургалтад хамруулна. | Насан туршийн боловсрол, ЕБС, СӨББ | | үйл ажиллагааны тоогоор үндэслэнэ. | 2024 онд нийт 3 удаагийн сургалт зохион байгуулсан. Давхардсан тоогоор 152 хүүхэд хамрагдсан. | Цэцэрлэгийн шинэчлэгдсэн хөтөлбөрийн хүрээнд хүүхэд бүрийн чадамжийн судалгааг гаргаж түүн дээрээ үндэслэн насны онцлог ялгаатай байдлыг харгалзан сургалтын хөтөлбөртөө тусган оруулж төлөвлөгөө боловсруулан сургалт үйл ажиллагаагаа явуулж байна. Ингэснээр хүүхэд бүрийн бие даан хөгжих үйлийг дэмжин чадварт нь суурилсан сургалтыг хэрэгжүүлж байна. Мөн зайнаас суралцаж байгаа хүүхдүүдийн эцэг, эх, асран хамгаалагчтай гурвалсан гэрээ байгуулж, бүлгийн багш нар тараах материал 50 ширхэгийг хэвлэж гэрт нь хүрч ажилласан.<br>ЕБС-д 2025-2026 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй сурагч элсээгүй.<br>Хөгжлийн бэрхшээлтэй насны 9 хүүхэд байгаагаас 0-18 хүртэлх насны буюу боловсрол эзэмших насанд хүрээгүй 2 хүүхэд байна. 2024-2025 оны хичээлийн жилд насан туршийн суралцахуйн сургалтад 1 суралцагч сурч байна.<br>Анхан шатнаас ахисан шат руу орсон. 55 хувьтай. Халамжийн сангаас гурван | 90 | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугуйт 320,000 төгрөгийн үнэтэй дугуйн хүсэлт явуулсан. | | |
| 15 | 2.2.3. Суралцагсдын дундах үе тэнгийн дээрэлхэлт, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, сургалтын байгууллагын орчинд цахим эрсдэлээс хамгаалах, дотуур байрын хүүхдийн амьдрах эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг сайжруулж, орон нутгийн хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулна. | ЕБС, СӨББ, ЗДТГ | | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоогоор | 2024 онд 6 удаагийн сургалтад давхарсан тоогоор 600 гаруй сурагч хамрагдсан | Цахим хэрэглээг даган цахим орчин дахь хууль бус үйлдлүүд /бусдын нэр хүндийг санаатайгаар, үндэслэлгүй гутаан доромжлох, иргэд, хэрэглэгчдийг төөрөгдүүлэх, хууран мэхлэх , төрөл бүрийн гэмт хэрэг, хүчирхийлэл, залилан/ ихээр гарах болсонтой холбогдуулан цахим орчны гэмт хэргийн талаар нийт 12 постер, мэдээлэл бэлтгэн иргэд, олон нийтэд түгээн ажилласан. Хүүхэд, багачууд, иргэд, албан хаагчдын цахим орчны хэрэглээг багасгах, цахим орчин дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Цахим орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Ухаалаг утасны зөв хэрэглээ” сэдэвт сургалт хэлэлцүүлгийн ажлыг зохион байгуулсан ба тус сургалтад нийт 45 сурагч хамрагдсан. Мөн сурагчдад нэгдсэн хэлэлцүүлэг 4 удаа, хорт зуршил болон үе тэнгийн дээрэлхэл, хүүхэд хамгаалал эрүүл ахуйтай холбогдуулан 4 удаагийн сургалт явуулсан. Сургалт хэлэлцүүлэгт давхардсан тоогоор дотуур байрын 340 гаруй сурагч хамрагдсан. Дотуур байрын сурагчдаас сэтгэл ханамжийн судалгааг жилд 2-удаа авсан. Эхний судалгаа 63,7% байсан бол 2 дахь судалгаа 17,3 хувиар өсөж 81% -д хүрж байрын багш ажилчдын ажил сайжирсан үр дүнтэй байлаа. Үе тэнгийн дээрэлхлээс урьдчилан сэргийлэх “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээлэл сурталчилгааны аяныг зохион байгуулж. Аяны хүрээнд сургуулийн орчинд сурагчдад дээрэлхлийн талаар ойлголт, мэдээлэл өгөх, хор уршгийг таниулах, урьдчилан сэргийлэх арга зам, дээрэлхэгчийг гэмт үйлдлээс татгалзах санаа сэдлийг өгөх олон талын ажил арга хэмжээг зохион байгуулсан. Аяны үр дүнд хүүхдийн эсрэг үйлдэгдсэн болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг, түүнчлэн бусдын эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг, зөрчлийн тоо буурсан, дээрэлхлийн талаар сурагч, багш, эцэг эхчүүд тодорхой мэдээлэлтэй болсон байна. Зурагт постер зургийг сургуулийн үүдэнд болон орж гарах хэсгүүдэд байршуулсан. Мөн үүдэнд байршуулсан телевизээр өдөр бүр видео контент, шторк, дууг бэлтгэн явуулсан байна. | | |
| 16 | 2.2.4. Ерөнхий боловсролын сургуулийн гадна биеийн тамирын иж бүрэн талбай бий болгож, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт их засвар, арчлалтын ажлыг хийнэ. | ЕБС, СӨББ | | Хийсэн ажлын тоогоор | Сумын зуун жилийн ойтой холбогдуулан засвар тохижилтийн ажил хийгдсэн. | Хугацаа болоогүй. | - | - |
| 17 | 2.2.5. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, цэцэрлэгийг бүрэн камержуулна. | ЕБС, СӨББ | ОНХСан-10,0 | Камержуулалтын хувь, засвар арчлалтын үр дүнгээр | | ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар орчин үеийн өндөр хүчин чадалтай, дуу дүрс бичдэг камераар гадна дотноо бүрэн камержуулсан. Нийт 17 камер суурилуулсан. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 18 | | | | | Хичээлийн байр болон дотуур байр бүрэн камертай. Хадгалах хугацаа 30 хоног | Гадна зогсоолын орчинд хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор явган хүний гарцын тэмдэг зогсоолын тэмдэг цэцэрлэгийн орчмын тэмдэг явган хүний замыг шинээр өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан хийж хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч гараас гарт хүргэх үйлчилгээг хэрэгжүүлэн ажилласан.<br><br>**ЕБС--ийн хувьд:** ЕБС өөрийн нөөц боломжоороо хичээлийн байрны болон дотуур байрын орчинг хянах 3 камерыг засварлан хадгалах хугацааг 30 хоног болгон сунгаж router болон lan утасыг сольж засвар үйлчилгээ хийж ажилласан. | | |
| 18 | 2.2.6. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гал тогоонд эрүүл ахуйн стандартад нийцүүлэн зарим тоног төхөөрөмжийг шинэчлэх | ЕБС, СӨББ | 294, 300 | Гал тогооны тоног төхөөрөмж шинэчилсэн хувиар | Гал тогооны тоног төхөөрөмжүүд ашиглалтын шаардлага хангахгүй байгаа | 2025-2026 оны хичээлийн жилд нөхөн хангалтын зардлаас дээжний хөргөгчийг үдийн цайны хоолны дээжийг хадгалах зориулалтаар худалдан авалт хийсэн.<br>2026 онд ОНХСангаар хийгдэх төсөл, хөтөлбөрийн саналд тусгагдан иргэдээс санал авсан. | 100 | - |
| 19 | 2.2.7. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн сургалтын баазыг нэмэгдүүлж, сургалтын чанарыг сайжруулна. | ЕБС, СӨББ | | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоогоор | | Хүүдийн насны онцлогт тохирсон, эрүүл ахуйн шаардлага болон стандартад нийцхүйц тоглоом наадгай, багш нарын сургалт үйл ажиллагаандаа ашиглах нэг удаагийн таваг, халбага, сэрээ -100 ш, модон хавчаар 100ш, эсгий бөмбөлөг 4 уут, сагс-20ш долоодой тоглоом- 20 ш, Савх-4уут тус бүр авч ажилласан. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ОНХС-13,76 Төсөл хөтөлбөр | | Бага боловсролын хүрээнд 2023-2024 оны хичээлийн жилд Eduten хөтөлбөр хэрэгжүүлэх цахим анги байгуулсан.<br><br>4 багшид зөөврийн компьютэр авч өгсөн. | ОНХСангаас 13,76 сая төгрөгийн 17 нэр төрлийн 140 ширхэг сургалтын хэрэглэгдэхүүн, core I7 зөөврийн компьютэр, өнгөт принтертэй болсон<br><br>**ЕБС- ийн хувьд:**<br>БШУЯ –аас Deseret олон улсын төслийн хүрээнд 19 chromebook, Туяа бага сургуулиас 29 табаар хангагдан суурь боловсролын хүрээнд Pearson хөтөлбөр хэрэгжүүлэх, цахим сургалтыг зохион байгуулах “**ЦАХИМ АНГИ”-**г байгуулсан.<br>Туяа бага сургуулийн сургалтын тоног төхөөрөмжөөс 5 багшийг сургалт зохион байгуулах зөөврийн компьютэр хангасан. | | |
| 20 | 2.2.8. Цэцэрлэгт шилэн кабель холбох ажлыг хийх | СӨББ | | Хийгдсэн ажлын хувиар | | Хугацаа болоогүй | - | - |
| **2.3.Багш, удирдах ажилтны мэргэжил, ур чадварыг дээшлүүлж, боловсон хүчний нөөц, нийгмийн баталгааг хангана.** | | | | | | | | |
| 21 | 2.3.1. Багш, удирдах ажилтны мэргэжил, арга зүйн тасралтгүй хөгжлийг дэмжих, нийгмийн баталгааг хангах бодлогыг хэрэгжүүлнэ. | ЕБС, СӨББ | | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтээр | 2024 онд Багшийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан сургалтуудад багш нар бүрэн хамрагдсан. | Боловсроын сайдын 2025 оны 1 сарын 23-ны өдрийн А/25 “Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам”- ыг багш нарт танилцуулан багшийн өөрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад нь чиглүүлэн ажилласан.<br>Сургуулийн багшийг хөгжүүлэх төлөвлөгөөнд багшийн арга зүйг хөгжүүлэх чиглэлээр 3 сургалт, | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | багшийн онолын мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр 2 ажил, багшийн технологийн чадварыг хөгжүүлэх ажлын байранд тасралтгүй хөгжүүлэх чиглэлээр 4 ажлыг тус тус төлөвлөн үйл ажиллагааны биелэлт 80% -тай хэрэгжсэн. Chadla.mn цахим платформоор багш нарын өөрийн үнэлгээг хийлгэж үр дүнгийн нэгдсэн тайланг гаргасан.бага ангийн 5 багш өөрийн үнэлгээ хийсэн. Үүнд:<br>Мини олимпиад \бага анги математик монгол хэлний судлагдахуунаар, суурь бүрэн дунд боловсролын хүрээнд математик, монгол хэл, гадаад хэл, түүх, физикийн судлагдахуунаар нийт 11 багш, 1- бүлгийн 202 сурагч хамрагдсан.\ Самбар төлөвлөлтийн уралдаан \2 сарын 1 - с, 4 сарын 1-ний хооронд 2 сарын аян зарлаж нийт 11 багш 44 ээлжит хичээлийн самбар төлөвлөлтөөр оролцсон. \ Шалгуурт нийцсэн даалгавар боловсруулах уралдаан: Уралдаанд бага ангийн 5 багш дунд, ахлах ангийн 9 багш оролцсон. Бага боловсролын түвшинд 25 нэгж хичээлийн даалгавар, ахлах дунд боловсролын түвшинд 18 нэгж хичээлийн даалгавар боловсруулан оролцсон. Багшийг ажлын байранд тасралтгүй хөгжүүлэх, даалгавар боловсруулах арга зүйг дэмжих зорилгоор аймгийн БГ-ын ахлах мэргэжилтэн Я.Энхтуяа багштай хамтран бага дунд боловсролын багш нарт “Олон үйлдэлт даалгавар боловсруулах арга зүй” сургалтыг зохион байгууллаа. Сургалтад 14 багш | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2 удирдах ажитан хамрагдсан. Мөн Арвайхээр сумын 5-р сургуулийн PREMIER мэргэжлийн хөгжлийн бүлгийн багш нартай хамтран багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг дэмжих, туршлага солилцох “ХАМТДАА ХӨГЖЬЕ – ХАМТААР ТҮГЭЭЕ” сургалт үйл ажилагааг зохион байгуулсан. Сургалт үйл ажиллагаанд 16 багш хамрагдсан. Bagsh.mn цахим платформын онлайн сургалтад 4 удирдах ажилтан 19 багш нийт 23 багш ажилтан хамрагдан өөрийн мэргэжил арга зүйгээ хөгжүүлж байна. Багш хөгжлийн зардлаас 1035.000 төгрөг сургалтын зардалд зарцуулсан<br>Бага ангийн 5 багш EDUTEN хөтөлбөрийн ахисан түвшний сургалтад цахимаар амжилттай хамрагдаж батламж авсан. Бага боловсролын сургалтын менежер удирдах ажилтны 7 дахь жилийн үндсэн сургалтад цахимаар амжилттай хамрагдан 85%-тай үнэлэгдэн батламжаа авсан. Мөн “МЭРГЭЖЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ, ЧАДАВХЖУУЛАХ ЦАХИМ-ТАНХИМ ХОСОЛСОН СУРГАЛТ”-д хамрагдан 82%-тай үнэлэгдэн ахисан түвшний гэрчилгээ авсан байна.<br>Цахим орчиноос суралцаж CANVA, CAP CUT, Gemini, Chagpt аппуудаар сургалт контентийг хийж canva- гийн сургалтад багш бүр өөрийгөө хөгжүүлэхийн тулд хиймэл оюун ухаан “AR“ ашиглан цаашид | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | илүү суралцаж байна.<br>2025-2026 оны хичээлийн жилд Bagsh.edu.mn платформын сургалтад 21 багш, удирдах ажилтан хамргадаж байна. Багш хөгжлийн зардлаас 840.000 төгрөгний төлбөрийг зарцуулсан.<br><br>HWPL олон улсын байгууллагын “Энх тайвны боловсрол -21” модуль сургалтад 16 багш хамрагдан суралцаж байна.<br><br>Иргэний оролцоо- Хөгжлийн гарц НҮТББ тай хамтран “Canva программын ахисан түвшний сургалтыг зохион байгууллаа. Сурлатад 18 багш 2 удирдах ажилтан хамрагдаж байууллагаас 1050,000 төлбөрийг төлж дэмжлэг үзүүлсэн.<br><br>СӨББ-ын нь багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих шинэчилсэн хөтөлбөрийн 3 өдрийн сургалтад эрхлэгч 4н багшийн хамт хамрагдсан. Мөн “**СӨБ-ын багш нарын мэргэжил дээшлүүлэх төрөлжсөн 2025” модуль** сарын сургалтад мэргэжлийн хөгжлийн бүлэг буюу бүлгийн багш нар амжилттай хамрагдаж үр бүтээлтэй ажиллаж байна. “Сургуулийн өмнөх боловсролын 3-5 насны хүүхдийн танин мэдэхүй, нийгэмшлийн чадварын үнэлгээний арга зүй” модуль сургалтад 2 багш хамрагдана. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Сургалтын хөтөлбөрт тохируулга / ялгаатай хэрэгцээтэй хүүхэд / хийх арга зүй” модуль сургалт, мөн “Илтгэл бичих арга, аргачлал “ сургалтад нэг багш хамрагдсан. | | |
| 22 | 2.3.2. Багш нарын ур чадвар, мэргэжлийг дээшлүүлэх, амжилт гаргасан багш нарыг урамшуулах зорилгоор гадаад улсад богино хугацааны сургалт, арга хэмжээнд хамруулна. | ЕБС, СӨББ | | Урамшуулал дэмжлэгт хамрагдсан багшийн тоогоор | Элсэлтийн ерөнхий шалгалт болон уралдаан тэмцээнд амжилт гаргасан нийт 3 багшид ур чадвар урамшуулал олгосон. | Элсэлтийн ерөнхий шалгалт болон уралдаан тэмцээнд амжилт гаргасан нийт 5 багш нарт ур чадвар урамшуулал олгосон. | 100 | 100 |
| 23 | 2.3.3. Суманд дутагдалтай байгаа математик, физик, хими, биологи, дуу хөгжмийн багш, англи хэлний мэргэжлийн багшаар хангах бодлого хэрэгжүүлэх | ЕБС | | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтээр | Дутагдалтай багш Математикийн – 1, Дуу хөгжмийн багш-1 | 2025-2026 оны хичээлийн жилд дутагдалтай байсан 2 багшийг сонгон шалгаруулалтаар авч ажилуулсан. Багшийн орон тоо бүрэн хангагдсан. | 100 | 100 |
| 24 | 2.3.4. Багшийн ёс зүйг эрхэмлэн сахих, багшийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | ЕБС, СӨББ | | Ёс зүйн дэд хорооны зохион байгуулсан ажлын тоогоор | Байгууллагууд ёс зүйн дэд хороогоо байгуулсан. | Сургуулийн дэргэдэх ёс зүйн дэд хороо 2025 оны 4 сард захирлын тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн батлагдаж 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 чиглэлээр 13 үйл ажиллагааг төлөвлөн 100 хувь хийж гүйцэтгэсэн. Үүнд: Байгууллагын багш ажилчдад “Төрийн албаны ёс зүйн тухай хууль”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээ” “ Сургуулийн өмнөх | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм” зэрэг эрх зүйн баримт бичгүүдээр цахимаар мэдээлэл түгээн ажилласан. 1-5-р ангийн сурагчдийн дунд "Шудрага байдал,- Шудрага иргэн" хэлэлцүүлэгийг зохион байгуулсан хэлэцүүлэгт 5 бүлгийн 97 сурагч хамрагдсан. Ёс зүйн хорооны мэдээллийн самбарыг шинэчлэн хийж мэдээллээр ханган ажиллаж байна. 5 сарын 12-16-ны хооронд “ТАЛАРХАЛ, УУЧЛАЛ”-ын 7 хоногийг зохион байгуулж энэ хугацаанд хамт олон, найз нөхөд, багш, эцэг эхдээ хаягласан 272 захидлыг эздэд нь хүргэж өгч хайр түгээн ажиллалаа. Багш ажилчдын дунд “ТА ТАА ТУНГАА” тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. Нийт 26 багш, ажилчид хамрагдсан. Мэргэжлийн зэргээ сунгах болон шинээр авах 11 багшийн талаарх сэтгэл ханамжийн судалгааг хамт олон, эцэг эх, суралцагч гэсэн 3 чиглэлээр авлаа. Хамт олны судалгаанд нийт 26 хүн, эцэг эхийн санал асуулгад 58 хүн, суралцагчийн санал асуулгад 74 суралцагч тус тус хамрагдсан байна. Судалгааны үр дүнг багш бүрээр гарган багш нарт нэг бүрчлэн танилцуулсан.<br>СӨББ нь 2025 оны 04 дүгээр сарын 14-с 05 дүгээр сарын 15-ны хооронд Байгууллагын хамт олны уур амьсгалыг сайжруулах, тэднийг өөртөө итгэлтэй чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Ёс зүйн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөлөөс “Өглөөний цэнэг, Өөрчлөлтийг өөрөөсөө” бид хамтдаа уриатай сарын CHALLENGE -г зохион байгуулсан. Тус аянаар дамжуулан багш, ажилтны дунд “Алтан хонх“, “АХА“, зэрэг танин мэдэхүйн хөгжилтэй тэмцээнүүдийг зохион байгуулж мэдлэг оюунаа хуваалцсан. Мөн “Талархалын аян“ гэсэн хайрцгаар дамжуулан багш, ажилтан болон эцэг, эх, асран хамгаалагчдын дунд бие биедээ талархал, мэндчилгээ, урмын үгсийг бичгээр бичиж илэрхийлсэн. Тус аянд байгууллагын 15 багш ажилтан болон бүлгийн хүүхдүүдийн, эцэг, эх, асран, хамгаалагчид оролцсон. | | |
| 25 | 2.3.5. Ерөнхий боловсролын сургуульд сэтгэл зүйч ажиллуулж, хүүхдийн сэтгэл зүй, ёс суртахууны асуудлыг анхаарч ажиллана. | ЕБС, СӨББ | | Сэтгэл зүйчийн орон тоогоор | - | Хугацаа болоогүй | - | - |
| **2.4.Иргэдийн насан туршдаа тасралтгүй суралцахуйг дэмжин, сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | | |
| 26 | 2.4.1. Насан туршийн боловсролын үндсэн чиглэлийг хөгжүүлж, албан бус сургалтыг зохион байгуулна. | ЕБС | | Зохион байгуулсан сургалтын тоогоор | Албан бус сургалтаар 4 сургалт зохион байгуулсан. | Насан туршийн боловсролын албан бус сургалтын хүрээнд угийн бичиг хөтлөлт, Мөнгөний долоо хоног, гамшгаас хамгаалах, Шинэ зууны малчин, аз жаргалтай гэр бүл, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, дэлхийн хуримтлалын өдөр гэх сургалт, өдөрлөгийг зохион байгуулж | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | давхардсан тоогоор 300 иргэн, 190 сурагч хамрагдсан. 2024-2025 оны хичээлийн жилд боловсрол нөхөн олгох сургалтаар 10 сурагч танхимын бусаар хамрагдаж байна. | | |
| 27 | 2.4.2. Насан туршийн сургалтын суралцахуйн өрөөг тохижуулна. | ЕБС | | Тохижуулсан өрөөний тоогоор | ЕБС-д Насан туршийн суралцахуйн төвийн өрөөтэй | Хугацаа болоогүй. | - | - |
| **Хэсгийн дундаж үнэлгээ:99,28**<br>**Хэсгийн дундаж үнэлгээ: 99,23** | | | | | | | | |
| **2.2. ЭРҮҮЛ МЭНД** | | | | | | | | |
| **2.2.1.Эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлж, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |
| 28 | 2.2.1.2. Халдварт бус өвчнөөс сэргийлэх "Эрүүл Монгол" хөтөлбөрийг салбар дундын оролцоотойгоор хувь хүн, гэр бүл, байгууллага, аж ахуйн нэгжийн хүрээнд хэрэгжүүлнэ. | ЭМТ | | Хамрагдсан иргэдийн хувиар | 70 хувь хамрагдсан. | Сумын хэмжээнд Артерийн гипертензи 1582 хүн хамрагдахаас 1313 хүн хамрагдаж 82,9%, чихрийн шижин 1178 хүн хамрагдахаас 913 хүн хамрагдаж 77,5%, хөхний хорт хавдраас сэргийлэх үзлэг – 627 хүн хамрагдахаас 409 хүн хамрагдаж 65,2%, умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх үзлэг 135 хүн хамрагдахаас 65 хүн хамрагдаж 48,1 %, элэгний хавдараас сэргийлэх 82 хүн хамрагдахаас 80 хүн хамрагдаж 97,5% явж байна. | 100 | 100 |
| 29 | 2.2.1.3. “Эрт илрүүлэг 2“ арга хэмжээний хүрээг зорилтот бүлэгт чиглүүлж, эмчилгээ, хяналт, урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | ЭМТ | | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоогоор | 60 хувь хамрагдсан. | Сумын хэмжээнд артерийн гипертензи 1582 хүн хамрагдахаас 1313 хүн хамрагдаж 82,9% ,чихрийн шижин 1178 хүн хамрагдахаас 913 хүн хамрагдаж 77,5% , хөхний хорт хавдраас сэргийлэх үзлэг – 627 хүн хамрагдахаас 409 хүн хамрагдаж 65,2%, умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх үзлэг 135 хүн хамрагдахаас | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 65 хүн хамрагдаж 48,1 %, элэгний хавдраас сэргийлэх – 82 хүн хамрагдахаас 80 хүн хамрагдаж 97,5% явж байна. Мөн хөдөө багуудаар үе шаттайгаар багийн эмчийн хамт явж урьдчилан сэргийлэх үзлэг хийж эмнэлгийн тусламж шаардлагатай иргэдийн СЭМТ-д хэвтүүлэн эмчилж мөн лавлагаа шатлалд явуулан тусламж үйлчилгээ тэгш хүртээмжтэй байхаар чиглэл болгон ажиллаж байна. | | |
| 30 | 2.2.1.4. Уламжлалт, сэргээн засах тусламж үйлчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж, уламжлалт эмийн хэрэглээг нэмэгдүүлнэ. | ЭМТ | - | Хамрагдсан иргэдийн тоогоор | 64 иргэн хамрагдсан | Сумын нийт иргэдэд тэгш хүртээмжтэйгээр уламжлалт болон сэргээн засах эмчилгээний нэр төрлийг олшруулах орчин цагийн анагаах ухаантай хослуулан тусламж үйлчилгээг үзүүлж байна. 2025 онд нийтдээ 125 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.<br>1. Бүтэн биеийн бариа<br>2. Хэсгийн бариа<br>3. Сүүн бариа<br>4. Тосон бариа<br>5. Сувгийн бариа<br>6. УВЧ эмчилгээ<br>7. Инфра улаан туяаны аппарат<br>8. Искра эмчилгээ<br>9. Поток аппарат<br>10. Хаш чулуун ор<br>Массажны гудас гэх мэт үйлчилгээг үзүүлж байна. | 100 | 100 |
| 31 | 2.2.1.5.“Эрүүл шүд” хөтөлбөрт хамрагдсан хүүхэд | ЭМТ | - | Хамрагдсан хүүхдийн тоо | Хамрагдаагүй. | 1 дүгээр ангийн 15 хүүхэд, 2 дугаар ангийн 19 хүүхэд, 8 дугаар ангийн 15 хүүхэд, дотуур байрны 50 хүүхэд, цэргийн насны буюу 18 насны 8 | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүүхдэд үзлэг хийж эмчилгээ шаардлагатай хүүхдүүдийг лавлагаа шатлалруу илгээж үзүүлэн хянаж ажиллаж байна. Нийт -107 хүүхэд хамрагдсан байна. | | |
| 32 | 2.2.1.7.Сумын төвийн иргэдийн ундны усны чанарыг сайжруулан гүний худагт ус цэвэршүүлэх төхөөрөмж тавьж эрүүл ахуйн шаардлага хангасан усан хангамжтай болох. | ЭМТ | ОНХС-20,0 сая | Үйлчлүүлсэн иргэдийн тоогоор | 2022 оны усны шинжилгээгээр ЭМТ-ийн худгийн ус эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй байсан. | ОНХСан болон Өрхийн тариалан бизнес хөгжил ТББ-ын хөрөнгөөр шинээр ундны усны 1 худаг гаргаж, цэвэршүүлэгч төхөөрөмж тавин ашиглалтанд оруулсан. | 100 | 100 |
| 33 | 2.2.1.8.Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх, тандалт судалгаа хийх, антибиотикийн зохистой хэрэглээнд хяналт тавина. | ЭМТ | | Үйлчлүүлсэн иргэдэд тандалт хийсэн хувиар | Тандалт хийгдээгүй | Эмийн хариуцсан сувилагч антиботик эмчилгээний гаж нөлөө болон зохистой хэрэглээ сэдвээр ажилчиддаа дотоодын сургалт , хэвтэн эмчлүүлж байгаа хүмүүс, амбулоториор үйлчлүүлж байгаа иргэдэд мэдээлэл сургалт хийж ажилласан.<br>СЭМТ-д бичил биетний тэсвэржилт буюу антибиотик мэдрэг болон нян ургуулах шинжилгээ хийгддэггүй энэ нь лавлагаа шатлалд хийгддэг нарийвчилсан тусгай шинжилгээ юм. | 100 | 100 |
| 34 | 2.2.1.9.Нийтийн халуун усыг түшиглэн эмчилгээ, сувилалын үйлчилгээ үзүүлнэ | ЭМТ | | Хэрэгжилтийн хувиар | 0 | Хугацаа болоогүй | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 35 | 2.2.1.10.Халдварт, халдварт бус өвчлөл бууруулах | ЭМТ | | Өвчлөлийн хувиар | Иргэдийн 10 хувийг хамруулсан. | В,С вирусын шинжилгээнд 2025 онд 395 иргэн /иргэд ,жирэмсэн ,цэргийн үзлэг /<br>ДОХ тэмбүүгийн шинжилгээгээр 2025 онд -228 иргэн /иргэд, жирэмсэн, цэргийн үзлэг / өвчний илрүүлэг шинжилгээнд хамрагдсан байна. Мөн халдварт бус өвчлөлөөр артерийн гипертензи 1582 хүн хамрагдахаас 1313 хүн хамрагдаж 82,9%,<br>чихрийн шижин 1178 хүн хамрагдахаас 913 хүн хамрагдаж 77,5% , хөхний хорт хавдраас сэргийлэх үзлэг 627 хүн хамрагдахаас 409 хүн хамрагдаж 65,2% , умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх үзлэг 135 хүн хамрагдахаас 121 хүн хамрагдаж 89,6 % , элэгний хавдраас сэргийлэх 82 хүн хамрагдахаас 80 хүн хамрагдаж 97,5% явж байна. Шинжилгээ үзлэгээр өөрчлөлттэй гарсан иргэдийг лавлагаа шатлалруу илгээж эргэн уялдан холбоотой ажиллаж байна. | 100 | 100 |
| 36 | 2.2.1.11. Нийгмийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор иргэдэд, сургалт сурталчилгааг, зохион байгуулах | ЭМТ | | | | Тарваган тахал өвчинөөс урьдчилан сэргийлэх сургалт хийж, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан. Сургалтанд 72 хүн хамрагдсан. Цахим орчинд тарваган тахлаас сэргийлэх мэдээ мэдээлэл, боршур байрлуулж иргэдэд цахимаар мэдээлэл хүргэсэн. Мэдээллийг Тарагт сумын хандалт ихтэй 8 пэйж хуудсанд хуваалцаж түгээсэн. ЭМТ-ийн пэйж хуудсанд 2 удаагын мэдээлэл оруулж 1268 үзэлт, 9 хариу үүлдэл 1 удаа хуваалцсан хандалттай байна. /Бусад пэйжийн | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хандалт тоонд ороогүй/. ЭМТ-ийн ажилчиддаа тарваган тахлын үеэр хэрэгжүүлэх арга хэмжээ болон тахлын хамгаалах хувцас хэрэглэлийг хэрхэн өмсөх, тайлах талаар сувилагч А.Нямсүрэн-тэй хамтран сургалт зохион байгуулсан. Сургалтанд ЭМТ-ын 17-н ажилчид хамрагдсан. Эмийн зохистой хэрэглээний дэлхийн 10 хоногийн аяны хүрээнд “Зөв цагт, зөв тунгаар” уриан дор ЭМТ-д хэвтэн эмчлүүлэгчид болон үйлчлүүлэгчидтэй уулзаж сургалт болон боршур тарааж мэдээлэл хүргэсэн. 3 хэвтэн эмчлүүлэгч, 21 үйлчлүүлэгчид мэдээлэл хүргэж, 20 боршур тараасан. Намрын цэрэг татлагын ажилтай холбогдуулан цэргийн насны залууст зориулан халдварт өвчинөөс сэргийлэх сургалт орж, боршур тараан ажилласан. 110-н цэргийн насны залууст мэдээлэл хүргэсэн. Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх 7 хоногийн аяны хүрээнд “Антибиотикийн зохистой хэрэглээ”-ний талаар ЭМТ-ийн ажилчид болон үйлчлүүлэгчидэд сургалт орж ажиллсан. ЭМТ-ийн 9 ажилтан цахим амлалтанд хүрч аяныг өндөрлүүлсэн. Чихрийн шижин өвчинтэй тэмцэх дэлхийн нийтийн өдрийг үндэслэн ЭМТ-өөр үйлчлүүлэгчидэд мэдээлэл сургалт хийсэн. Цахим орчинд мэдээлэл байршуулж олон нийтэд зөвлөмж хүргэсэн. Мэдээллийг 784 хүн үзэж, 4-н хандалт, 1 удаа хуваалцсан үзүүлэлттэй байна. Халдварт өвчинтэй тэмцэх , сэргийлэх арга хэмжээний хүрээнд Томуу, томуу төст өвчиний | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | урьдчилан сэргийлэх ажлыг ЭМТ эмч мэргэжилтнүүдийн хамтаар хийж. СӨБ болон ЕБС-ийн байгууллагуудад сургалт, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Сургалтанд 8 ажилтан, СӨБ-ын 20 хүүхдийн эцэг эх хамрагдав. Ахлах сувилагч С.ОРОЛМАА хамт ЕБС-ийн дотуур байрны сурагчдад амны хөндийн ариун цэвэр шүдний оо болон сойзыг зөв ашиглах хэрхэн сонгох талаар сургалт орж эрүүл мэндийн боловсрол олгож ажилласан сургалтанд 49-н хүүхэд 1 ажилчин хамрагдсан. Эрүүл мэндийн боловсрол дээшлүүлэх ажлын хүрээнд хувийн ариун цэвэр сахиулах талаар сургалт зөвлөгөө өгч, дотуур байрны хүүхдүүдийг ахлах сувилагчийн хамтаар үзлэг хийж шаардлагатай гэж үзсэн хүүхдүүдэд нэмэлт зөвлөгөө хүргэж ажилласан. Ахлах сувилагч С.Оролмаа гарыг хэрхэн угаах, хувийн ариун цэвэр сахиулах тал дээр мэдээлэл өгч ажиллав. Сургалтанд 46 хүүхэд хамрагдаж 5 -н хүүхдэд нэмэлт ариун цэвэр хангах зөвлөгөө хүргэв. ХДХВ/ДОХ-ын эсрэг дэлхийн нийтийн өдрийг тохиолдуулан ЕБС-ын 9-12 дураар ангийн сурагчдад сургалт орж, сургачидтай чөлөөт ярилцлага хийв. Сургалтын дараагаар сургалтанд хамрагдсан хүүхдүүдийн дунд АХА тэмцээн зохион байгуулж, эхний 3-н байрыг шалгаруулж өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулав. Тус АХА уралдаанд 12 дугаар ангийн 3-н сурагч эхний байруудыг ээзлж шагнуулсан. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих зорилгийн хүрээнд ЭМТ-ийн ажилчдын дунд Ёс зүйн дэд хороотой хамтран салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулан ажилчидтайгаа кофетой өглөөний уулзалтыг зохион байгуулж, ажилчид өөрсдийн санаачлагаар хөгжөөнт тоглоом тоглуулах ёс зүйн төлөвшил түүчээлэх ажил зохион байгуулж хамтын санаачлага хөдөлмөрөөр эрх зүйн орчин сайжруулах, хамт олон нийгэмийн сэтгэл ханамжийн нөхцөл сайжруулах ажил хийж ажлын байран дахь сэтгэл зүй, сэтгэл ханамжтай орчин сургалт мэдээлэл хүргэсэн. | | |
| **2.2.4.Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, нийгмийн баталгааг сайжруулж, эрүүл мэндийн ажилтны чадамжид суурилсан бүтээмжийг тасралтгүй дээшлүүлнэ.** | | | | | | | | |
| 37 | 2.2.4.1. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, хөгжил, нийгмийн баталгааг сайжруулах сумын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ. | ЭМТ | - | Хөтөлбөрийн хэрэгжилтээр | 0 | Хугацаа болоогүй | - | - |
| 38 | 2.2.4.2. Эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн салбарт суралцаж буй их, дээд сургуулийн суралцагчтай гэрээ байгуулж төлбөрийн дэмжлэг үзүүлж орон | ЭМТ | Орон нутгийн төсөв 5,0 | Гэрээ байгуулан ажиллуулж буй нарийн мэргэжлийн эмчийн тоогоор | 0 | Тарагт сумаас эрүүл мэндийн болон нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр суралцаж байгаа оюутан залуусыг хөдөө орон нутагт ажиллах боломж нөхцлийг танилцуулсан.Түүний дагуу хүний нөөцөө бүрэн бүрдүүлэх чиглэлээр анхааран ажиллаж байна. Энэ онд нарийн мэргэжлийн 2 эх | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нутагтаа ажиллуулах хүний нөөцийн бодлогыг барьж ажиллана. | | | | | эмчтэй гэрээ байгуулан ажиллаж байна. | | |
| 39 | 2.2.4.3 Тогтвор суурьшилтай 5 болон түүнээс дээш ажиллаж байгаа эмч нартай гэрээ байгуулан урамшуулал олгох | ЭМТ | | | Хуулийн дагуу урамшуулал дэмжлэгийг олгосон. | Тогтвор суурьшилтай ажиллуулах бололцоогоор хангаж хөдөө орон нутгийн нэмэгдэл цалингийн шатлал, үр дүнгийн мөнгийг олгох 3 жил ажиллаад мөнгөн тэтгэмжинд хамрагдах түүнээс дээш жил ажиллах үед хөдөлмөрийн тухай хуулинд заасны дагуу цалин нэмэгдүүлэх,ээлжийн амралтын хугацаа уртсах зэрэг боломжуудыг танилцуулж хөдөлмөр эрхлэхээр зөвшөөрсөн ажилтантай гэрээ байгуулан ажиллаж байгаа. | 100 | 100 |
| 40 | 2.2.4.4 Хөдөөгийн багийн төвд байнгын оршин суудаг эмч нарыг унаагаар үе шаттай хангана. | ЭМТ | | Унаагаар хангасан хувиар | 0 | Хугацаа болоогүй | - | - |
| **Хэсгийн дундаж үнэлгээ:100**<br>**Хэсгийн дундаж үнэлгээ:100** | | | | | | | | |
| **2.3. ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ** | | | | | | | | |
| **2.3.2.Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хөгжүүлэх бодлогыг салбар дундын хамтын ажиллагаатай хэрэгжүүлж, хүүхэд хамгааллыг сайжруулна**. | | | | | | | | |
| 41 | 2.3.2.1. “Хайрлагдсан хүүхэд” төслийг хэрэгжүүлж, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг сайжруулна. | ЗДТГ | | Хамрагдсан хүүхдийн тоогоор | Хүүхэд хамгааллын бодлогыг байгууллага бүрт танилцуулсан. | Сумын төсөвт байгууллагуудын “Хүүхэд хамгааллын бодлого” бодлогын хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулсан. Албан байгууллага бүр “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг хэрэгжүүлж, хэрэгжилтийн хүрээнд Хөдөлмөрийн тухай хуулийн | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Орон нутгийн төсөв, иргэн, ААН | | | 43.3 дахь заалтыг \Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэн, сурталчилан таниулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.<br>Хүүхдийн байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ой, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Нэг бэлэг–Нэг инээмсэглэл” аяныг зохион байгуулж, нийт 174 бэлэг цуглуулан зорилтод бүлгийн хүүхдүүдэд гардуулсан. Үүнтэй холбогдуулан 2–18 насны хүүхдүүдэд зориулсан 6 төрлийн тэмцээн, уралдааныг зохион байгуулж, сумын төсөвт байгууллагууд эхний 5 байрыг ивээн тэтгэсэн.<br>Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавигдах шаардлага MNS 6715:2019 стандарт, ЗГ-ын 2019 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллах ажлын хүрээнд: Сумын баяр наадам, багийн өдөрлөг зэрэг 8 наадамд давхардсан тоогоор 320 хүүхдийн хамгаалах хэрэгсэл, даатгал, бие, сэтгэл зүйн эрүүл мэндэд хяналт тавьж ажилласан. Уралдааны явцад 6 хүүхэд мориноос унасан тохиолдол | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гарсныг эрүүл мэндийн төвөөс ажилласан эмч анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн.<br>Олон улсын охидын эрхийг хамгаалах өдрийн хүрээнд өсвөр насны охидын эрүүл мэнд, ариун цэврийн мэдлэгийг нэмэгдүүлэх, сургуулийн орчинд охидод ээлтэй орчин бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулав. Өсвөр насны охидод зориулсан “Өсвөр насны охидын эрүүл мэнд ба өөрийгөө хайрлах нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж, биеийн болон сэтгэлзүйн эрүүл мэнд, ариун цэврийн зөв дадал, сарын тэмдгийн үеийн зөв арчилгаа зэрэг сэдвээр мэдээлэл өглөө. Мөн ЕБС-ийн охидын ариун цэврийн өрөөнд “Охидын булан” байгуулж, ариун цэврийн хэрэгсэл, гарын авлага, зөвлөмжийг байрлуулан байнгын ашиглалттай орчин бүрдүүллээ.<br>Эрсдэлт нөхцөлд амьдарч буй 11 өрхийн 36 хүүхдийг илрүүлж, нөхцөл байдлын үнэлгээ хийж, эрсдэлийн даатгалд хамруулсан.<br>Ихбулаг багийн сургууль завсардсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрээр жилд 4-с доошгүй удаа очиж нөхцөл байдлын үнэлгээ хийж, гэрийн даалгавар өгч ажилласан.<br>Хараа хяналт сул 6 хүүхдийг ЕБС-ийн Дотуур байранд хамруулж, аюулгүй байдалд хяналт тавин ажиллаж байна. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 42 | 2.3.2.2. Хүүхэд, өсвөр үеийнхнийг осол гэмтэлд өртөх, хорт зуршилд автахаас урьдчилан сэргийлэх, цахим орчны зохистой хэрэглээг бий болгох зорилгоор нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулна. | Насан туршийн суралцахуйн төв | | Сургалтад хамрагдсан хүүхэд, эцэг, эхчүүдийн тоогоор | 2 удаагийн үйл ажиллагаанд 20 хүүхэд хамрагдсан. | Сумын төвийн худалдаа эрхлэгч нарт насанд хүрээгүй хүүхдэд ахуйн хэрэглээний газ худалдан борлуулахгүй байх анхааруулга санамж хүргүүлж, мөн иргэдэд хүүхэд ахуйн хэрэглээний газ, бензин үнэрлэснээсүүдэн гарах хор хөнөөл, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөний талаар гарын авлага тарааж мэдээлэл хүргэсэн.<br>Хүүхдийг хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, зөв дадал хэвшил төлөвшүүлэх сургалт зохион байгуулсан. Сургалтын үеэр тамхи, архи, мансууруулах бодис зэрэг хорт зуршлын хүний эрүүл мэнд, зан төлөв, амьдралын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар мэдлэг олгож, хорт зуршлаас ангид байх, зөв амьдралын хэв маягт суралцахын ач холбогдлыг онцоллоо. Сургалтад 33 сурагч хамрагдсан.<br>Гамшиг онцгой байдлын үе дэх хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд: ЕБС-ийн дэргэдэх Эко клубийн сурагчидтай хамтран Хүүхэд залуучуудад байгаль орчинтой зөв харьцах, гамшиг, ослын үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулсан. Сургалтад 50 гаурй сурагч хамрагдсан.<br>Сурагчдын Бие даалтын 7 хоногийн хүрээнд ЕБС-ийн бага ангийн сурагчдад “Зөв зохистой цахим хэрэглээ” сэдвээр сургалт зохион | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллаа. Сургалтад 1-5-р ангийн 64 хүүхэд хамрагдлаа. | | |
| 43 | 2.3.2.3. Нийгмийн ажилтан ажиллуулна. | ЗДТГ | | Нийгмийн ажилтны жилийн ажлын тайланг үндэслэнэ | 0 | Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Засгийн газрын 237 дугаар тогтоол гарч, Монгол Улсад анх удаа анхан шатанд буюу сум хороодод хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтнууд ц ажиллах боломж бүрдсэн. Энэ шийдвэрийн дагуу Тарагт сумын ЗДТГ-ын Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан орон тоонд 2025 оны 02 сарын 06-ны өдөр шинээр томилогдож, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудыг ажлын байранд нь чиглүүлэх, мэргэжлийн ур чадварыг нь нэмэгдүүлэх чадавхжуулах сургалтуудад хамрагдаж, ажиллах нөхцөл боломжоор хангуулан ажиллаж байна. Сумын ЗДТГ-аас нөөтбүүк, шинэ ширээ сандал болон бусад шаардлагатай бичиг хэрэг, тоног төхөөрөмжөөр хангасан. | 100 | 100 |
| | **2.3.3.Залуучуудын бүх талын хөгжилд дэмжлэг үзүүлж, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 44 | 2.3.3.1. Залуучуудын боловсролын болон мэргэжлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох | ЗДТГ | | Залуучуудын оролцоог дэмжиж зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | Залуучуудруу чиглэсэн 5 сургалт арга хэмжээг зохион байгуулсан. | Өвөрхангай аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 01/122 дугаартай албан тоотын дагуу сумын Залуучуудын | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | оролцоог дэмжсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | | | | | хөгжлийн зөвлөлийг нийгмийн салбар бүрийн төлөөллийг оролцуулан 9 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсан.<br>“Залуучуудын хөгжлийн тухай” хуулийн танилцуулга – Хуулийн гол зорилго, зарчим, залуучуудын оролцоо, эрх, үүргийн талаар зөвлөлийн гишүүдэд танилцуулсан.<br>Залуу малчдад хэрэгцээтэй мэдлэг, ур чадварыг төлөвшүүлэх, бодит мэдээлэл түгээх зорилгоор Өвөрхангай аймгийн Насан туршийн суралцахуйн төвөөс санаачлан боловсруулж байгаа тоглоомын арга зүйд суурилсан сургалтын хөтөлбөрийг туршин сайжруулах “Шинэ зууны малчин” хэлэлцүүлэг зохион байгуулагдсан. Тус хэлэлцүүлэгт 31 малчид, иргэдийн төлөөлөл оролцсон.<br>Цэрэг татлагын үйл ажиллагааны хүрээнд аймгийн Насан туршийн суралцахуйн төв, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын хамтарсан сургалтын баг цэргийн насны залуучуудад: “”Эрчүүдэд тулгамдаж буй асуудлууд”, “Эерэг харилцаа, хандлага”, “Гэр бүл төлөвлөлт” сэдвүүдээр сургалт зохион байгууллаа. Тус сургалтад 70 гаруй залуучууд хамрагдсан.<br>Монгол улс Анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах Улсаа тунхагласны түүхт 101 жилийн ойг тохиолдуулан “Иргэний андгай өргөх | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ёслол"-ыг 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгууллаа. Иргэний андгай өргөх ёслолд 16 нас хүрч иргэний үнэмлэхээ гардан авч буй 10 сурагч оролцон иргэний андгай өргөлөө.<br>2025 оны 01 сарын 10-с 01 сарын 12-ны хооронд Спортын 5 төрөлд тэмцээн \шатар, дартс, шагайн харваа, волейбол, ширээний теннис\-ийг зохион байгуулсан. Тус тэмцээнд 18-35 насны 156 иргэн хамрагдсан. Үүнээс эмэгтэй тамирчин 54% байна.<br>Хорт зуршил, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах ажлын хүрээнд: Электрон тамхи татдаг ахлах ангийн 4 сурагчийг илрүүлж, зөвлөгөө өгч ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад "Электрон тамхи болон утаат тамхи"-ны хор уршиг сургалтыг зохион байгуулсан. Мөн хорт зуршлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр танхимын сургалтыг 2 удаа зохион байгуулж, дээрх сургалтуудад нийт 200 гаруй сурагчдыг хамруулсан.<br>Багийн засаг дарга нартай хамтран 18-35 насны залуучуудын судалгааг \хөдөлмөр эрхлэлт, гэр бүлийн байдлаар\ гаргалаа. Сумын хэмжээнд 18-35 насны 764 залуучууд байна. Энэ нь нийт хүн амын 24,6%-ийг эзэлж байна. Үүнээс эмэгтэй 58,5%, эрэгтэй 41,5% байна. Залуучуудыг хөдөлмөр боловсролын түвшингээр нь авч үзвэл: Одоо суралцаж байгаа 11%, Бакалаврын дээд 35,2% ,Дипломын | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дээд 5,6%, Техникийн болон мэргэжлийн 9,2%, Тусгай мэргэжлийн дунд 1,8%, Бүрэн дунд 18,3%, Суурь 12,4%, Бага 6,2%, Боловсролгүй 0,3%, Гэрлэлтийн байдлаар нь авч үзвэл: Гэрлэлтээ батлуулсан 59,2%, Гэрлэлтээ батлуулаагүй 12,9%, Огт гэрлээгүй 26,28%, Тусгаарласан 0,5%, Цуцалсан 1,1%, Бэлэвсэн 0,02% Хөдөлмөр эрхлэлтийн байдлаар нь авч үзвэл: Төрийн байгууллагад ажилладаг 13,7%, Хувиараа хөдөлмөр эрхэлдэг 39,31%, Малчин 26,5%, Ажилгүй 19,4%, Хөдөлмөр эрхлэх чадваргүй 0,06%, Гадаадад 1,03%, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 17 буюу нийт залуучуудын 0,02%-ийг тус тус эзэлж байна. | | |
| 45 | 2.3.3.2. Залуучуудад гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн “Аз жаргалтай гэр бүл” сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлж, залуучуудын хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | ЗДТГ | | Нийгмийн ажилтны жилийн ажлын тайланг үндэслэнэ | 0 | Гэр бүлийн үнэ цэнэ, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан төрийн байгууллагуудын албан хаагчид тэдний гэр бүлд чиглэсэн “Хамтдаа жаргалтай” сургалт, нөлөөллийн ажлыг 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулж 12 гэр бүл хамрагдсан байна.<br>Тус өдөрлөгөөр:<br>-"Хайр" кино хэлэлцүүлэг,<br>-"Хамтдаа хөгжилдье" хөгжөөнт тэмцээн,<br>- "Аз жаргалтай дурсамж" ярилцлага,<br>- "Хайрын илгээмж" ,<br>- "Жаргалтай мөч" | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - "Гэрэл түгээе"<br>- "Хайрын үдэш" зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулав. | | |
| 46 | 2.3.3.3. Зорилтот бүлгийн залуучуудыг хөгжлийн үйлчилгээнд хамруулах, “Залуусын боломж” явуулын үйлчилгээг нэвтрүүлж, хөдөөгийн залуучуудын хөгжил оролцоог нэмэгдүүлнэ. | Төрийн байгууллагууд | | Хөдөөд явуулын үйлчилгээг үзүүлсэн тоогоор | 0 | Зорилтод бүлгийн залуучуудыг хөгжлийн үйлчилгээнд хамруулах ажлын хүрээнд Сумын аварга шалгаруулах “Адуучин – 2025” тэмцээнийг 2025 оны 07 дугаар сарын 07-нд зохион байгуулсан. Тус тэмцээнд Тарагт сумын 6 багийн 50 гаруй залуучууд оролцсон. Тэмцээнд шидгээр шалгарсан залуучуудыг Өвөрхангай аймгийн аварга шалгаруулах “HORSE FESTIVAL – 2025” арга хэмжээнд оролцоход нь сум орон нутгийн зүгээс хоол хүнс, цагаан идээгээр дэмжлэг үзүүлсэн.<br>Жил бүр сумын иргэдийн хамтын ажиллагаа, спорт сонирхлыг дэмжих, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, уламжлалт спортын төрлүүдийг хөгжүүлэх зорилгоор жил бүр сумын 6 багийн өдөрлөг наадмыг уламжлал болгон зохион байгуулж байна. Өдөрлөгийн үеэр залуу бөхчүүдийн барилдаан, дэмбээ, гар барилдаан зэрэг бусад уралдаан тэмцээнүүд тогтмол зохион байгуулдаг бөгөөд дунджаар 100 гаруй хамрагдаж байна. | 100 | 100 |
| 47 | 2.3.3.4. Төрийн бүх шатны байгууллага залуу албан хаагчдыг сургах, дадлагажуулах, ур чадварыг дээшлүүлэх үйл | ЗДТГ | | Үйл ажиллагааны тоогоор | Төрийн 5 байгууллага залуу боловсон хүчинг дотроо дадлагажуулж, зөвлөн тусалж дэмжлэг | Төрийн байгууллагуудаас авсан судалгаагаар 50 орчим хувь нь залуу боловсон хүснээр хангагдсан байна. Залуу албан хаагчдыг салбарынх нь сургалтанд танхимаар болон цахимаар тухай бүр байгууллага бүр дэмжин бүрэн хамруулж байна. ЭМТ- | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааг хэрэгжүүлнэ. | | | | үзүүлдэг.Цахимаар сургалтанд хамрагдах орчин нөхцлийг бүрэн хангасан. | ийн албан хаагчдыг Арвайхээр сумын Уян сэтгэл өрхийн эмнэлэгт дадлага хийлгэсэн. ЭМТ-ийн даргаар томилогдон ирсэн залуу эмчийг аймгийн ЭМГ-аас БОЭТ болон Баянгол сумын ЭМТ-д дадлагажуулсан. | | |
| 48 | 2.3.3.5. Төр, иргэний нийгмийн болон зорилтот бүлгийн иргэд рүү чиглэсэн сайн дурын ажил, санал санаачилгыг бүх талаар дэмжинэ. | ЗДТГ | Улсын төсөв, Иргэн, ААН | Дэмжлэг үзүүлсэн тоогоор | 0 | Багийн засаг дарга нар Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нартай хамтран зорилтод бүлгийн айл өрхийн судалгааг гаргаж, хөдөлмөр эрхлээгүй, амьжиргааны түвшин доогуур, сургууль, цэцэрлэгт 3 ба түүнээс дээш хүүхэд хамрагддаг айл өрхүүдийг сонгон авч:<br>Мод арчлах, ургуулах нийтийг хамарсан ажилд 5 иргэнийг түр ажлын байраар хангаж,<br>Хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлага хангасан зорилтот бүлгийн өрх, гишүүнд хүнс тэжээлийн дэмжлэг үйлчилгээ үзүүлэх үйлчилгээнд 10 өрхийн 54 иргэн хамрагдаж байгаагаас байнгын ажлын байранд 1 иргэн, түр ажлын байранд 1 иргэн ажилд орсон байна.<br>Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, шаардлагатай үйлчилгээ авахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор: Иргэн Ж.Т-ийн охин Т.Б эмчилгээнд зориулж төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд Хандивын аяныг зохион байгуулсан бөгөөд аяны хүрээнд Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүний уриалгыг гаргаж, тус | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | уриалгад ЗДТГ, ЭМТ, СӨББ-ын хамт олон нэгдэж нийт 1,170,000₮ хандивыг цуглуулан ар гэрт нь хүлээлгэн өглөө. Ихбулаг багийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьдрах орчныг сайжруулах, төсөл арга хэмжээнд хамруулах ажлыг Арвайхээр сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль, Тусгай хэрэгцээт сургуулийн захиргаатай хамтран зохион байгуулж, 4 ханатай иж бүрэн тавилгатай гэр өгсөн. Мөн хүүхдийн ар гэрт хоол хүнс, ахуйн хэрэглээний бараа бүтээгдэхүүнээр дэмжлэг үзүүлж, оршин суугаа газрын гэрчилгээг гаргаж өгсөн. Хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах, шаардлагатай хэрэглэгдэхүүнээр дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд ЕБС-ийн 1-р ангид элсэн орсон зорилтод бүлгийн хагас өнчин 2 хүүхдэд форм, мөн хагас өнчин, асран хамгаалагч нь хөгжлийн бэрхшээлтэй 2 хүүхдэд хичээлийн хэрэглэгдэхүүнийг өгсөн. Зорилтод бүлгийн 5 хүүхдийг Хужирт сумын Цагаан залаа зусланд амраасан. | | |
| 49 | 2.3.2.6. Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх фитнесийн өрөө ажиллуулах | ЗДТГ | ОНХС-38,0 | Үйл ажиллагаа явуулж буй фитнесийн тоогоор | 0 | 2025 оны Орон нутгийн сангийн хөрөнгө оруулалтаар 38,000,000 төгрөгөөр фитнесийн өрөөг тохижуулсан. Фитнес клуб нь 2025 оны 04 дүгээр сарын 22-с эхлэн үйл ажиллагаагаа тогтмол явуулж байгна. Фитнесийн өрөөнд нэмэлтээр душ, хувцасны өрөөг шийдэж, тохижуулсан. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Одоогоор эвдрэл, гэмтэл гарсан тоног төхөөрөмж байхгүй. Тогтмол хичээллэдэг иргэдийн тоо 23 байна. | | |
| 50 | 2.3.2.7. Хуучин наадмын талбайг тохижуулан соёл амралтын хүрээлэн болгон өргөжүүлэх. | ЗДТГ | Орон нутгийн төсөв | Үйл ажиллагааны тоогоор | 2014 онд засвар тохижилтийн ажлыг хийсэн. 2023 онд тойруулж хашаалан мод тарьсан. | Хугацаа болоогүй | - | - |
| **Хэсгийн дундаж үнэлгээ:100**<br>**Хэсгийн дундаж үнэлгээ: 100** | | | | | | | | |
| **2.4. ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ӨВ СОЁЛ** | | | | | | | | |
| **2.4.1.Соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулна.** | | | | | | | | |
| 51 | 2.4.1.1. Соёлын биет болон биет бус өвийг судлан шинжлэх, түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн уламжлуулах, хамгаалах бодлогыг хэрэгжүүлнэ. | Соёлын төв | | Үйл ажиллагааны тоогоор | Соёлын биет болон биет бус өвийг судлан шинжлэх, түгээж, дэлгэрүүлэн өвлүүлэн уламжлуулах, хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр 5 ажил зохион байгуулсан. | Соёлын биет болон биет бус өвийг сурталчилах, өвлөн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор соёлын биет бус өв Ардын дуу болон хэл хуурын дугуйлан хичээллэж 36 сурагч хамрагдаж Өвөрхангай аймагт болсон ерөөл магтаалчдын анхдугаар наадамд хөгжмийн багш, соёлын өвийн ажилтан нар гурван сурагчийн хамт оролцож нүүдэлчин дэлхийн фестивальд оролцохоор шалгарч батламж гардан авч Улаанбаатар хот Тайж хайрханы бэлд болсон нүүдэлчин дэлхийн фестивальд амжилттай оролцож нэг шавь нь дэлхийн фестивальд шилдэг гранпри шагнал авч шилдэг өвлөн уламжлагч болж орон нутгийхаа нэрийг гарган амжилттай оролцоод ирсэн. Соёлын биет бус өвийг сурталчилан түгээн дэргэрүүлж амжилт гаргасан хөгжмийн | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | багш, соёлын өвийн ажилтан нар Өвөрхангай аймгийн шилдэг өвлөн уламжлагч батламж гардан авсан амжилтай. Одоогийн байдлаар монгол өв соёл шагайн наадгайн дугуйлан, ардын дууны дугуйлан, хэл хуурын дугуйлан зэрэг соёлын биет бус өвийн дугуйлангууд хичээллэж түгээн дэлгэрүүлж байна.<br>Өвөрхангай Даншигийн гоёо наадамд соёлын өвийн ажилтан хөгжмийн багшийн хамт өөрийн оёсон дээл хүрмээр гангаран оролцож Дэд байрт шалгарсан. Соёлын биет бус өв шагайн наадгайн тэмцээнийг насанд хүрэгч, өсвөр гэсэн 2 төрлөөр зохион явуулж ард иргэд болон сурагчид идэвхтэй хамрагдсан.<br>Энэ онд нийт | | |
| 52 | 2.4.1.2. Улаан ламын хийдийн үйл ажиллагааг сэргээн, хурал номын үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлэх | Соёлын төв | - | Дэмжлэгийн хувиар | - | Хугацаа болоогүй | - | - |
| 53 | 2.4.1.3. Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлж, морин хуурын шавь сургалтыг зохион байгуулж, дэмжин ажиллана. | Соёлын төв | - | Хамрагдсан хүүхдийн тоогоор | Морин хуурын сургалтанд хөгжмийн багш Ш.Батбилэг хамрагдан ажиллаж байна. | Морин хуурыг эрхэмлэн дээдлэж түгээн дэлгэрүүлэх зорилгоор Хөгжмийн багш аймгийн ХДТ-т морин хуурын сургалтанд хамрагдаж сумандаа морин хуурын шавь сургалт хичээллүүлэх эхлэлийг тавиад байна. | 70 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 54 | 2.4.1.4. Хэл хуурын хувцас, хөгжим хэрэгслээр хангах | Соёлын төв | Улсын төсөв-1,1 | Хамрагдсан хүүхдийн тоогоор | Хэл хуурын дугуйлан хичээллэж байна | Хэл хуурын хувцас хэрэглэлтэй болохоор загвар дизайныг гаргасан. Хэл хуурын шавь сургалтыг насанд хүрэгчид болон сурагчдад хичээллээд 50 суралцагчидтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Соёлын төвөөс 5 хэл хуураар сургалтыг явуулж байсан ба сурагчдад хэл хуурыг захиалан өгч хэл хуураар хангасан, соёлын төвөөс 1,100,000 төгрөгөөр хэл хуур авсан. | 100 | 100 |
| 55 | 2.4.1.5. Багуудын өдөрлөгүүдийг зохион байгуулан ардын авъяастнуудыг нээн илрүүлж, цаашид хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх | Соёлын төв | - | Соёлын төвийн жилийн эцсийн тайланг үндэслэнэ. | Багуудын өдөрлөгүүдийг зохион байгуулан ардын авъяастнуудыг нээн илрүүлж ажиллаж байна. | Багуудын өдөрлөгийг 8 дугаар сарын 01-10-ыг хүртэл зохион байгуулан, 6 багт нүүдлийн хэлбэрээр соёл урлагийн нэгдсэн арга хэмжээг явуулсан. Мөн ардын дууг хэн сайн дуулах вэ дуун цэнгүүнийг зохион байгуулсан. Нийт 976 хүн хамрагдсан. Шаардлага хангасан ардын авьяастнуудыг өвлөн уламжлагчдын бүртгэлд бүртгэсэн. | 100 | 100 |
| **2.4.2.Бүх нийтийн соёлын боловсролыг олгох үйл ажиллагааг орон нутгийн онцлогт тохируулан шинэлэг арга хэлбэр ашиглан хөгжүүлж, хүний нөөцийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |
| 56 | 2.4.2.1. Үндэсний соёлын өв түүх, хэл соёл, ёс заншилд тулгуурлан “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлж, иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна. | Соёлын төв | | Явуулсан арга хэмжээний тоогоор | Үндэсний соёлын өв түүх, хэл соёл, ёс заншилд тулгуурлан “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлэн ажилаж байна. | Таргат сумын соёлын төв нь Үндэсний өв түүх, хэл соёл, ёс заншилд тулгуурлан бүх нийтийн болловсролын арга хэмжээг хэрэгжүүлэх соён гэгээрүүлэх ажлын хүрээнд:<br>ЕБС-ийн сурагчдын дунд Соёлын өвийн бага наадам 2 удаа зохион явуулж давхардсан тоогоор 356 сурагч хамрагдсан. 1-5 дугаар ангийн сурагчидтай ТСҮХДГ-уудаар явган аялал хийж, сурагчдын дунд ТСҮХДГ гэж юу вэ? АХА тэмцээн зохион явуулж 69 сурагч оролцсон. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Соёлын биет бус өв Шагайн наадгайн тэмцээнийг насанд хүрэгч, өсвөр гэсэн 2 төрлөөр зохион явуулж ард иргэд болон сурагчид идэвхтэй хамрагдаж 159 хүн оролцсон. Ард иргэдийг соён гэгээрүүлэх тэднийг орчин цагтай хөл нийлүүлэн бүжиглэж гоо зүйн хүмүүжил олгох зорилгоор заавал сурах 16 бүжгийг зааж Хаврын баяр-2025 нийтийн бүжгийн тэмцээнд Хамтлаг бүжгийн төрөлд Гутгаарт байрт шалгарсан амжилттай . Одоогийн байдлаар 7 хоног бүрийн пүрэв гарагт нийтийн бүжиг зааж здэшлэг цэнгүүн зохион явуулж хэвшээд байна 2025 оны байдлаар нийтийн бүжигт давхардсан тоогоор нийт 1856 хүн хамрагдаад байна. Хөдөөгийн багуудаар 9 удаа нүүдлийн соёл урлагийн арга хэмжээг зохион явуулж нийт 568 хүн хамрагдаад байна. Угийн бичиг хөтлөх аян зарлаж сумын ард иргэдэд Соёлын өвийн ажилтан “Ураг удам мөнхөд оршиг “ сэдэвт лекц, угийн бичиг хөтлөх ач тус сургалт зохиошн явуулж ард иргэд амжилтай хамрагдан одоогийн байдлаар суманд 50 гаруй өрх угийн бичгээ хөтлөж эхлээд байна. Тарагт сум ӨВ аймгийн угийн бичиг аянд сумаараа Дэд байрт шалгарч, Соёлын өвийн ажилтан Угийн бичгээр аймгийн шилдэг өрх болсон амжилттай | | |
| 57 | 2.4.2.1 Номын сангийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн, номын сангийн сан хөмрөгт 2,0-оос | Соёлын төв | - | Цахимжуулсан хувиар | Номын сангийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг эхлүүлсэн. | Номын сангийн LibU4 программд 3000 номыг нэг бүрчилэн шивж оруулсан ингэснээр уншигчдыг цахимаар бүртгэн коджуулж номыг уншлагад | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | доошгүй сая төгрөгөөр баяжилт хийнэ. | | | | | гарган ажиллаж байна. Номын санд баяжилт хийгдээгүй. | | |
| | 2.4.2.2. Бүх нийтийн соёлын боловсрол хөтөлбөрийг хангаН ажиллах | Соёлын төв | | Явуулсан арга хэмжээний тоогоор | Бүх нийтийн соёлын боловсрол хөтөлбөрийг хангаН ажиллаж байна | Боловсрол хөтөлбөрийн хүрээнд хэл хуурын булан байгуулан шавь сургалтыг 50 суралцагчидтай үйл ажиллагаа явуулж байна. Мөн хэл хуурыг сурталчилан түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимтэй өрнүүлэн МУХХХ-ны ерөнхийлөгчтэй хамтран олон талт ажлууд хийж гүйцэтгэсэн. Үүнд: Хэл хуурыг сурталчилан таниулах зорилгоор МУХХХ-ны ерөнхийлөгчийг сумандаа урьж, хүүхэд залуусыг сургалтанд хамруулсан. 95 хүн хамрагдсан. Соёлын төвдөө хэл хуурын булан, боловсролын хөтөлбөрийг чий болгож, хэл хуур авсан. Шавь сургалтыг хичээллэхээр дугуйлан байгуулсан. Хөгжмийн багш, соёлын өвийн ажилтан нар Хэл хуурыг тээгч түгээгч гэр бүлээр шалгарч, холбогдох бүхий л тэмцээнд оролцож тэргүүлсэн. Нүүдэлчин дэлхийн соёлын фестивальд 2 шавийн хамт оролцож, гранпри шагналыг хүртсэн. Одоогоор хэл хуурын 45 суралцагчидтай үйл ажиллагаа явуулж байна. | 100 | 100 |
| 58 | 2.4.3.2. Соёл, урлагийн байгууллагын орчин нөхцөлийг сайжруулан, тоног төхөөрөмжөөр хангаН ажиллана. | Соёлын төв | ОНХС-39,6 | Тоног төхөөрөмжөөр хангагдсан байдлаар | Соёл, урлагийн байгууллагын орчин нөхцөлийг сайжруулан, тоног төхөөрөмжөөр хангаН ажиллаж байна | Соёлын төв нь орон нутаг хөгжлийн сангаар 6Х3 хэмжээтэй лед дэлгэц, зөөврийн компьютэртэй болсон. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 59 | 2.4.3.4. Багуудын өдөрлөгүүдийг зохион байгуулан ардын авъяастнуудыг нээн илрүүлж, цаашид хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх | Соёлын төв | - | Соёлын төвийн жилийн эцсийн тайланг үндэслэнэ | Багийн өдөрлөгүүдийг зохион байгуулсан. | Багуудын өдөрлөгийг 8 дугаар сарын 01-10-ыг хүртэл зохион байгуулан, 6-н багт нүүдлийн хэлбэрээр соёл урлагийн нэгдсэн арга хэмжээг явуулсан. Мөн ардын дууг хэн сайн дуулах вэ дуун цэнгүүнийг зохион байгуулсан. Нийт 976 хүн хамрагдсан. Шаардлага хангасан ардын авьяастнуудыг өвлөн уламжлагчдын бүртгэлд бүртгэсэн. | 100 | 100 |
| 60 | Дутагдалтай байгаа уран бүтээлчдийг орон нутагт ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, хүний нөөцийн тогтвортой байдлыг ханган ажиллана. | - | - | - | - | - | - | - |
| **Хэсгийн дундаж үнэлгээ:97**<br>**Хэсгийн дундаж үнэлгээ: 100** | | | | | | | | |
| **2.5. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ** | | | | | | | | |
| **2.5.1.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн салбар хоорондын хамтын ажиллагаа, бодлогын уялдааг хангах замаар ажлын байр бий болгоно.** | | | | | | | | |
| 61 | 2.5.1.1. Сумын бүтээн байгуулалт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр хөнгөлөлттэй зээлд хамруулах замаар ажлын байр бий болгоно. | ЗДТГ | | Шинээр нэмэгдсэн ажлын байрны тоо | Хадгалагдсан ажлын байр 18, ажлын байр шинээр нэмэгдээгүй. | “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн” дэмжлэгт хамрагдах иргэдэд мэдээлэл зөвлөгөө өгч, Ахмад настны санхүүгийн дэмжлэгт-1 иргэн гэрийн хошлон,өрхний оосор хийх төслөөр 5.000.000 төгрөгний санхүүжилт авсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний санхүүгийн дэмжлэгт-1 иргэн дугуй засвар ажиллуулахаар төслөө иргүүлж 10 сард 5.000.000 төгрөгний 50 хувийн эргэн төлөлттэй хүүгүй зээлд хамрагдан дугуй засварын тоног төхөөрөмжөө | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | авч 4 сард дугуй засвараа нээхээр бэлтгэл ажлаа хангасан.<br>Иргэний санхүүгийн дэмжлэгт-1 иргэн малын гаралтай дайвар бүтээгдэхүүнээр гар урлал хийх төсөл ирүүлж хөдөлмөр 5.000.000 төгрөгний хүүгүй зээл авч хөөрөгний даалин,даллаганы уут, гоёл чимэглэлийн уут зэрэг 20 гаруй төрлийн бүтээгдэхүүн хийж улсын үзэсгэлэн худалдаанд оролсон. Мөн бараа бүтээгдэхүүн 10 гаруй аймагт 30-иад сумдад захиалга аван борлуулалт хийж байна.<br>Мод арчлах, ургуулах нийтийг хамарсан ажилд түр ажилд 5 иргэн 3 хоногийн мод усалгаа хийж тус бүр 150.000 төгрөгний цалин авсан.<br>зөвлөгөө өгч шинэ ажлын байранд 18 иргэнийг бүртгэн ажиллалаа<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээлийн мэдээллийг иргэдэд хүргэн ажиллаж байна.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн малжуулах төсөлд 1 өрх 8.000.000 төгрөгний санхүүжилт авч 27 хургатай хонь 21 ишигтэй ямаа худалдан авч малжсан. Ахмад мэргэжилтний зөвлөн туслах үйлчилгээнд ахмад Тарагт сумын эрүүл мэндийн төвд 120 цагийн зөвлөх үйлчилгээ үзүүлж 1.080.000 төгрөгний цалин авсан. | | |
| 62 | 2.5.1.2. Бизнес хөгжлийн төвтэй болж эмэгтэйчүүд, жижиг дунд бизнес | ЗДТГ | 60,0 | Дэмжсэн үйл ажиллагааны тоогоор | 0 | Бизнес хөгжлийн төвийн засварын ажил бүрэн дуусч хүлээн авсан.<br>Цайны газар, буудал, талх нарийн боовны цех, оёдлын цех, суран эдлэл, үсчин, бариа заслын төвүүдийг | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эрхлэгчдийг дэмжиж ажиллана. | | | | | ажиллуулахаар төлөвлөсөн. Зарлал тавьж 5 иргэн үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлт өгсөн байна. Уг төвийн халаатын шугамыг холбосны дараа үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөөд байна. | | |
| 63 | 2.5.1.3. Политехник коллежийн суралцагчдыг орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурлан сургах байдлаар зохион байгуулж, ажлын байранд зуучилна. | ЗДТГ | | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоогоор | Хүнд машин теханизмын операторчины ангид 2 иргэн хамрагдаж төгссөн. | Өвөрхангай аймгийн Политехникийн коллежид нэг иргэн гоо сайханчаар 1 жилийн хугацаатай насанд хүрэгчдийн оройн ангид суралцаж байна.Ажил мэргэжлийн чиг баримжаа, олгох сургалтад 5 иргэн суухаар бүртгүүлээд байна. | 100 | 100 |
| | **2.5.6.Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж, нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар авах боломжийг бүрдүүлнэ**. | | | | | | | |
| 64 | 2.5.6.1. Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг ил тод түргэн шуурхай хүртээмжтэй хүргэнэ. | ЗДТГ | | Цахим үйлчилгээг үйлчлүүлэгдэд хүргэсэн хувиар | Цахим үйлчилгээг иргэдэд сурталчилсан. | Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд суманд “СИКОС” программ нэвтэрсэн. Энэ хүрээнд нийт нийгмийн даатгалын 34 үйлчилгээг цахимаар хүргэн ажиллаж байна. Нийт 453 иргэн, аж ахуйн нэгж, даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар өгч ажилласан. | 100 | 100 |
| 65 | 2.5.6.2. Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчдыг нийгмийн даатгалд хамруулж, тэдний нийгмийн баталгааг хангана. | ЗДТГ | | Нийгмийн даатгалд хамрагдсан тоогоор | 270 иргэн нийгмийн даатгалд хамрагдсан. | Жилийн эцсийн байдлаар сайн дурын нийгмийн даатгалд шинээр нийт 407 хүнийг хамруулсан. Үүнээс малчны сайн дурын даатгалд 362 малчин, энгийн сайн дурын даатгалд 18 иргэн, 0-3 насны хүүхдээ асарч буй эхийн сайн дурын даатгалд 18 эх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эхийн сайн дурын даатгалд 9 эхийг тус тус шимтгэл төлүүлсэн. | 100 | 100 |
| | | | | | | | | **Хэсгийн дундаж үнэлгээ:100**<br>**Хэсгийн дундаж үнэлгээ: 100** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2.6. БИЕИЙН ТАМИР, СПОРТ** | | | | | | | | |
| **2.6.1.Хүн амыг идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэж, эрүүл мэндээ дэмжихэд чиглэсэн олон талт орчин нөхцөл, боломжоор хангаж, нийтийн биеийн тамирын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн бие бялдарын хөгжил, боловсролыг дээшлүүлнэ.** | | | | | | | | |
| 66 | 2.6.1.1. Иргэдийг эрүүл чийрэг, бүтээлч зан чанарыг эрхэмлэсэн өдөр тутмын дасгал хөдөлгөөн, зөв хооллолт, эрүүл амьдралын хэв маяг бүхий дадалд сургаж, шинэ санал санаачилгыг дэмжин хамтран ажиллана. | ЗДТГ, ЭМТ | | Хамрагдсан иргэд тоо | Төрийн байгууллагын албан хаагчид ажлын байрны дасгал хөдөлгөөнд хамрагддаг. | Идэвхтэй хөдөлгөөн, эрүүл амьдралын хэвшил бүхий иргэн, хамт олныг дэмжих, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, ажлын бүтээмжийг сайжруулах, спортын ээлтэй, эерэг, эрүүл ажлын байрны орчныг бүрдүүлэх зорилгоор албан байгууллагуудын дунд ажлын байрны дасгал хөдөлгөөн хийх аяныг зохион байгуулсан. СӨББ, ЗДТГ идэвхитэй хамрагдсан. Соёлын төвд нийтийн цэнгээнт бүжгийн сургалт зохион байгуулагдаж 12 иргэн идэвхитэй хамрагдаж байна. Сумын төрийн байгууллагын албан хаагчид ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж байна. Аз жаргалын курс хичээллэж 23 иргэн хамрагдсан.ЕБС-ийн хүүхдүүд болон СӨББ-ийн хүүхдүүдийн дунд танин мэдэхүйн 2 удаагийн аялалыг зохион байгуулж 45 хүүхэд хамрагдсан. Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн дардасын клуб хичээллэж байна. | 100 | 100 |
| 67 | 2.6.1.2. Фитнессийн өрөөг бий болгон тоног төхөөрөмжөөр хангана. | ЗДТГ, Соёлын төв | 38,0 | Фитнесийн өрөөтэй болсон байдлаар | 0 | 2025 оны Орон нутгийн сангийн хөрөнгө оруулалтаар 38,000,000 төгрөгөөр фитнесийн өрөөг тохижуулсан. Фитнес клуб нь 2025 оны 04 дүгээр сарын 22-с эхлэн үйл ажиллагаагаа тогтмол явуулж байгна. Фитнесийн өрөөнд нэмэлтээр душ, | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувцасны өрөөг шийдэж, тохижуулсан. Одоогоор эвдрэл, гэмтэл гарсан тоног төхөөрөмж байхгүй. Тогтмол хичээллэдэг иргэдийн тоо 23 байна. | | |
| 68 | 2.6.1.3. Өсвөр үеийн волейбол, сагсан бөмбөг, хөлбөмбөг, шатар, ширээний теннис, дардас зэрэг спортын төрлүүдээр мэргэжлийн дасгалжуулагч ажиллуулж дэмжин ажиллана. | ЗДТГ, ЕБС | | Спортын төрлөөр хичээллэж буй иргэдийн тоо | Өсвөр үеийн волейбол, дардасаар хичээллэж буй 10 хүүхэд байна. | Биеийн тамир, спортын чиглэлээр сум, аймаг, бүсийн чанартай тэмцээн уралдаанд оролцож буй баг, тамирчдад сум орон нутгийн зүгээс унаа болон шатахууны зардлыг шийдвэрлэж, тэмцээн уралдаанд оролцох боломжийг бүрдүүлж өгдөг.<br>Монгол Улсын Засгийн газраас бүсчилсэн хөгжил реформыг эхлүүлсэнтэй холбогдуулан Өвөрхангай аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Бүсчилсэн хөгжил хөдөлгөөн”-ний хүрээнд зохион байгуулагдаж буй иргэдийн спортын их наадмын төвийн бүсийн анхан шатны шалгаруулалт Арвайхээр суманд амжилттай зохион байгуулагдаж, Анхан шатны шалгаруулалтад Тарагт сумаас 80 гаруй тамирчид оролцсоноос 11 төрөлд шагналт байр эзэлж, шигшээ тэмцээнд 4 тамирчин шалгарч, Архангай аймагт зохион байгуулагдсан тэмцээнд ширээний теннисний төрөлд Н.Бямбадолгор Гутгаар байр эзэлсэн амжилттай байна.<br>Мөн 2025 оны байдлаар сумын хэмжээнд спортын чиглэлээр нийт 27 төрлийн арга хэмжээ зохион байгуулагдаж давхардсан тоогоор нийт 1400 гаруй иргэд хамрагдсан. | 90 | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Аймаг, бүсийн, улсын хэмжээнд нийт 16 удаагийн уралдаан тэмцээн зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 350 гаруй тамирчин сум орон нутгаа төлөөлөн оролцож, шагналт байранд шалгарсан амжилттай байна. | | |
| 69 | 2.6.1.4. Урлаг, спортын авъяасыг нээн илрүүлэх, хөгжих боломжийг олгох зорилгоор сумаас төрсөн спортын алдартнуудын нэрэмжит уралдаан тэмжээнүүдийг зохион байгуулж алдаршуулах | ЗДТГ, ЕБС | | Урлаг, спортын чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны тоогоор | Урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулагдсан. | Өвөрхангай аймгийн Тарагт сумын харьяат Монгол Улсын Мэргэн Сосорбурамын Алтангэрэл, Аймгийн Тод Мэргэн Чулуунбатын Батжаргал, Мөнхсаруулын Батбаатар, Ванябаатарын Дониддэмбэрэл нарын цолны мялаалга, Арвайнталын уухай шагайн зөвлөлийн 10 жилийн ойн тэмцээн 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Тарагт суманд зохионд байгуулагдсан. Тус тэмцээнд 21 багийн 190 гаруй тамирчин оролцсон. Сумы Заан Б.Алтанхуягийн нэрэмжит өсвөрийн бөхийн барилдаан, гар бөмбөгийн тэмцээнийг амжилттай зохион байгуулж 42 хүүхэд хамрагдсан. Үе үеийн төгсөгчдийн спортын тэмцээн 3 насны ангилалаар зохион байгуулагдаж 20 багийн 170 иргэн оролцов. | 100 | 100 |

**Хэсгийн дундаж үнэлгээ: 97,5**
**Хэсгийн дундаж үнэлгээ: 97,5**

## ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

### 3.1.ТӨСӨВ, САНХҮҮ

**3.1.1.Төсөв үр ашигтай, хэмнэлтэй байхаар төлөвлөгдөж зарцуулагдсан, татварын орлого нэмэгдэж, бүх шатны хяналт, шалгалт эрсдэлд суурилан хийгдсэн санхүүгийн зах зээлд оролцогч иргэдийн тоо нэмэгдсэн байна.**

<table>
<tr>
<td>70</td>
<td>3.1.1.1. Сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийг үр дүнд суурилан төлөвлөж, гүйцэтгэлийг хангана.</td>
<td>ЗДТГ</td>
<td>3,222.9</td>
<td>Төсвийн зарчмыг баримталсан байна.</td>
<td>Сумын 2024 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 2,436,621.9 мянган төгрөгөөр баталсан.</td>
<td>Сумын 2025 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 3,222,967.1 (гурван тэрбум хоёр зуун хорин хоёр сая есөн зуун жаран долоон мянга нэг зуу) мянган төгрөгөөр баталж, төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагад доорхи хөтөлбөрөөр батлагдсан төсвийн нэгтгүүллээ.
<table>
<tr><td>Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга</td><td>302,548.8</td></tr>
<tr><td>Урсгал зардлын дээд хэмжээ Үүнээс: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал</td><td>277,172.5</td></tr>
<tr><td>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал</td><td>1,800.0</td></tr>
<tr><td>Мэдээлэл сурталчилгааны зардал</td><td>3,400.0</td></tr>
<tr><td>Ажил олгогчоос олгох тэтгэмж</td><td>500.0</td></tr>
<tr><td>Багийн Иргэдийн нийтийн Хурлын даргын урамшуулал</td><td>19,676.3</td></tr>
<tr><td>Засаг дарга</td><td>1,567,748<br>1</td></tr>
<tr><td>Сумын Засаг даргын Тамгын газар</td><td>1,567,748<br>1</td></tr>
<tr><td>Урсгал зардал</td><td>956,138.8</td></tr>
<tr><td>Орон нутгийн нөөц хөрөнгө</td><td>38,000.0</td></tr>
<tr><td>Багийн захиргаа</td><td>235,609.3</td></tr>
<tr><td>Ажил олгогчоос олгох тэтгэмж</td><td>4,000.0</td></tr>
<tr><td>Хур хог хаягдал, орчны бохирдлыг цэвэрлэх үйлчилгээ</td><td>5,000.0</td></tr>
<tr><td>Улсын баяр наадам</td><td>10,000.0</td></tr>
<tr><td>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх</td><td>2,400.0</td></tr>
</table>
</td>
<td>100</td>
<td>100</td>
</tr>
</table>

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td><table>
<tr><td>Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардал</td><td>160,200.0</td></tr>
<tr><td>Хөрөнгө оруулалт</td><td>151,100.0</td></tr>
<tr><td>Ахмадын сан</td><td>5,300.0</td></tr>
<tr><td>Улсын төсвийн байгууллагуудын тогтмол зардал</td><td>401,670.2</td></tr>
<tr><td>Ерөнхий боловсролын сургуулийн  тогтмол зардал</td><td>215,782.5</td></tr>
<tr><td>Туяа бага Ерөнхий боловсролын сургуулийн тогтмол зардал</td><td>10,100.0</td></tr>
<tr><td>Эрүүл мэндийн төвийн тогтмол зардал</td><td>49,948.0</td></tr>
<tr><td>Сургуулийн өмнөх боловсролын байгууллагийн тогтмол зардал</td><td>44,047.2</td></tr>
<tr><td>Соёлын төвийн тогтмол зардал</td><td>81,792.5</td></tr>
<tr><td>Орон нутгийн хөгжлийн сан</td><td>690,000.0</td></tr>
<tr><td>Хоршоо хөгжүүлэх сан</td><td>161,000.0</td></tr>
<tr><td>Эрсдэлээс хамгаалах сан</td><td>100,000.0</td></tr>
</table></td><td></td><td></td></tr>
<tr><td>71</td><td>3.1.1.2. Иргэн, аж ахуйн нэгжийн татварын боловсрол, татвар төлөх сэтгэлгээ хандлагыг сайжруулах замаар татварын бааз суурийг нэмэгдүүлэн, татварын орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлнэ.</td><td>ЗДТГ</td><td></td><td>Татварын орлогын хувиар</td><td>Аймгийн төсөвт 18858,0<br>Сумын төсөвт 836,021.8 ЗДТГазар 150.0</td><td><table>
<tr><th>Орлогын төрөл</th><th>Батлагдсан</th><th>Гүйцэтгэл</th><th>Зөрүү</th><th>Хувь</th></tr>
<tr><td>ОТБИОА татвар</td><td>79,500.00</td><td>66,500.00</td><td>13,000.00</td><td>83.6</td></tr>
<tr><td>Бууны татвар</td><td>1,000.00</td><td>240.00</td><td>760.00</td><td>24.0</td></tr>
<tr><td>Улсын тэмдэгт</td><td>1,200.00</td><td>12,887.20</td><td>(11,687.20)</td><td>1073.9</td></tr>
</table></td><td>100</td><td>100</td></tr>
</table>

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хог хаягдал | 6,000.00 | 791.60 | 5,208.40 | 13.2 | | |
| | | | | | | Хүү торгуулийн орлого | 13,000.00 | 14,700.00 | (1,700.00) | 113.1 | | |
| | | | | | | ҮХХБор орлого | 2,400.00 | 4,200.00 | (1,800.00) | 175.0 | | |
| | | | | | | Хадгаламжийн хүүгийн орлого | 14,000.00 | 14,991.00 | (991.00) | 107.1 | | |
| | | | | | | Газрын төлбөр | 28,500.00 | 17,500.00 | 11,000.00 | 61.4 | | |
| | | | | | | Суутган | 306,940.00 | 277,500.00 | 29,440.00 | 90.4 | | |
| | | | | | | Нохойны албан тавар | 500.00 | | 500.00 | 0.0 | | |
| | | | | | | ҮХХАТатвар | 6,300.00 | 3,800.00 | 2,500.00 | 60.3 | | |
| | | | | | | Агнуурын орлого | 69,000.00 | 187,920.00 | (118,920.00) | 272.3 | | |
| | | | | | | ТТАМБ | | 0.40 | (0.40) | 100.0 | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| татварын буцаалт | (24,091.30) | (24,091.30) | - | 100.0 |
| Дүн | 504,248.70 | 576,938.90 | (72,690.20) | 114.4 |

Иргэн, аж ахуй нэгжүүдийн татварын боловсролыг дээшлүүлэх зорилгоор танхимын сургалт 4 удаа зохион байгуулж 36 татвар төлөгч болон хувь хүн, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад “Татварын тухай ойлголт” сэдвээр сургалт хийж 42 сурагчийг тус тус хамруулсан.  Мөн суманд үйл ажиллагаа явуулдаг хүнсний дэлгүүрийн эздэд ААНОАТТ хуулийн шинэчилсэн найруулгаар сургалт хийсэн.

Татвар төлөгчдөд Татварын ерөнхий газар болон аймгийн Татварын газраас өгч буй мэдээ мэдээллүүдийг цаг тухай бүрт нь сумынхаа фэйсбүүк группүүдэд байршуулан мэдээ мэдээллийг хүргэн ажиллаж байна. Татварын бааз суурийг нэмэгдүүлэх зорилгоор 2024 онд үйл ажиллагааны орлоготой хувь хүний жагсаалтыг ахлах мэргэжилтнээс авч 267 иргэний тайланг илгээсэн нь өмнөх оноос 11 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Энэ онд жилийн эцсийн байдлаар 176 иргэнээс 11,3 сая төгрөгний хувь хүний орлогын албан татвар төвлөрүүлсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 2 дахин өссөн үзүүлэлттэй харагдаж байна.

Улс, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг сарчилсан хуваарийн дагуу жигд ханган биелүүлж ажиллаж байна. Эхний 11 сарын байдлаар орон нутгин татварын орлого 127 хувийн биелэлттэй байна.

**3.1.4.Төрийн худалдан авах ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэх замаар хүний оролцоог бууруулж, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлнэ.**

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 72 | 3.1.4.1. Төрийн худалдан авах ажиллагаанд цахимаар худалдан авах ажиллагааг хэрэгжүүлнэ. | ЗДТГ | 1,069.1 | Мэргэжлийн байгууллагын үнэлгээг үндэслэнэ. | Худалдан авах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулсан байна, -Төрийн байгууллагад ашиглагдах байнгын хэрэгцээтэй бараа бүтээгдэхүүнийг цахим дэлгүүрээс худалдан авсан байна. | Орон нутгийн хөгжлийн сан, төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх худалдан авах ажиллагааг Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан ерөнхий төлөвлөгөөг www.tender.gov.mn цахим хуудсанд байршуулж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хэлтэсээр батлуулж, Tender.gov.mn сайтад нийтэлсэн. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр хийгдэх Туяа багт худгийн онгоц 30,000.0 мянган төгрөг (Жирмийн өгөөж ХХК шалгарч, 29,400.0 мянган төгрөгний гэрээ байгуулагдсан, бараа хүлээн авсан), Сумын төвийн гүний худагт цэвэршүүлэх төхөөрөмж суурьлуулах, худаг засварлах 20,000.0 мянган төгрөг (иргэн Б. Бямбажаргалтай 20,000.0 мянган төгрөгний гэрээ байгуулагдсан, ажил хүлээж авсан), СӨББайгууллагын хүүхдийн сургалтын бааз нэмэгдүүлэх 14,000.0 мянган төгрөг (иргэн Б. Дуламхүүтэй 13,760.0 мянган төгрөгний гэрээ байгуулагдсан, ажил хүлээж авсан), Иргэний танхимын тохижилт 20,000.0 мянган төгрөг (Бэхт арвай ХХК-тай 19,980.0 мянган төгрөгний гэрээ байгуулагдсан, ажил хүлээж авсан), СӨББайгууллагын камержуулалт 10,000.0 мянган төгрөг (Өвөрхангай цахим сүлжээ ХХК-тай 9,645.0 мянган төгрөгний гэрээ байгуулагдсан, ажил хүлээж авсан), Фитнесийн тоног төхөөрөмж 40,000.0 мянган төгрөг (Санаа мед ХХК-тай 38,490.0 мянган төгрөгний гэрээ байгуулж, хүлээж авсан), Бизнес хөгжлийн төвийг засварлах 62,895.1 мянган төгрөг (Арвай хийц ХХК- | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тай 62,496.2 мянган төгрөгний гэрээ байгуулж, хүлээж авсан), Сумын хэсэгчилсэн төлөвлөгөөний зураг төсөв хийх 12,000.0 мянган төгрөг (Баянгол прожект ХХК-тай 12,000.0 мянган төгрөгний гэрээ байгуулж, хүлээж авсан), Соёлын төвд лед дэлгэц авах 40,000.0 мянган төгрөг (Баянгол прожект ХХК-тай 39,600.0 мянган төгрөгний гэрээ байгуулж, хүлээж авсан),<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ЕБСургуулийн хоол, үдийн цай, шатахууны 202,618.0 мянган төгрөгний тендер зарлагдсан боловч оролцогч байхгүй амжилтгүй болсон. | | |
| 73 | 3.1.4.2. Төрийн худалдан авах ажиллагааны мэдээллийг цахим системээр дамжуулан олон нийтэд хүргэх хүртээмжийг нэмэгдүүлнэ. | ЗДТГ | 1,069.0 | Цахим системд байршуулсан мэдээллийн тоо | 100 хувь | Нийт 1,069,127.0 мянган төгрөгний 31 худалдан авалт төлөвлөснөөс 18 тендерийн урилгаар 33 цахим тендер шалгаруулалт зарласан. Гомдол гарсан тендер шалгаруулалт 3 байна. Гомдлын дагуу зөрчил илрээгүй.<br>Зарлагдсан тендерийн урилгыг худалдан авах ажиллагааны цахим хуудас, сумын вэб хуудсанд байршуулсан. Үнэлгээний хорооны гишүүдэд зааварчилгаа өгч ажиллаж байна. Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгдээгүй. | 100 | 100 |
| 74 | 3.1.4.3. Бүх шатны худалдан авах ажиллагаанд болон түүний гүйцэтгэлийн явцад хяналт, шалгалтыг тогтмол явуулж, иргэд олон нийтийг мэдээллээр хангана. | ЗДТГ | 61.5 | Жилийн гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хувиар 90-100 хувь бол 28 % | Сумын 2024 оны үнэлгээ<br>72,6 хувь 61,2 сая төгрөгийн урамшуулал | Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ 2025 оны үнэлгээ 81,5 хувьтай 61,5 сая төгрөгийн урамшуулал авахаар үнэлүүлсэн. Onhs.mof.gov.mn сайтад 2024 оны хэрэгжилт, 2025 оны төлөвлөлт, хэрэгжилт, 2026 оны төлөвлөлтийг бүрэн оруулж, 2026 онд хийгдэх хөрөнгө оруулалтын | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 80-90 хувь бол 23 % | | төлөвлөлтөнд цахим санал асуулга өгөхөд бэлтгэсэн. Нийт цахим санал асуулгад 64 иргэн давхардсан тоогоор 768 санал, нэмэлтээр 19 санал тусгасан байна. ОНХсангийн гүйцэтгэлийн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулсан. ИТхурлаас 2025 оны ОНХСангийн хэрэгжилтэнд хөрөнгө оруулалт бүр дээр хяналт хийгдэж байгаа. Өмч хөрөнгийн асуудлыг хүлээж авах акт гарснаар байгууллагад хүлээлгэн өгч, хөрөнгийн бүртгэлд тусгаж байна. | | |
| 75 | 3.1.4.4. Татварын бааз суурийг бэхжүүлэн хуулийн хугацаандаа татвараа сайн төлсөн иргэн ,албан байгууллагыг урамшуулан хамтран ажиллана. | ЗДТГ | | Урамшуулсан татвар төлөгчийн тоогоор | 0 | Хугацаа болоогүй | - | - |
| 76 | 3.1.4.5. Иргэд олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлж, хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцох, хуримтлал, хадгаламжтай болох хандлагыг дээшлүүлнэ | ЗДТГ, ЕБС | | Зохион байгуулсан сургалт, үйл ажиллагааны тоогоор | 0 | Дэлхийн хуримтлалын өдөр 2025 аяны хүрээнд Насан туршийн суралцахуйн төв, Өвөрхангай аймгийн Монголбанкны хэлтэстэй хамтран “Хуримтлал” сэдэвт сургалт нөлөөлийн үйл ажиллагааг ЕБСургуулийн 66 суралцагчид болон 30 төрийн албан хаагчдын дунд явуулсан.<br>Мөн төрийн банктай хамтран Санхүүд суралцая сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн 35 сурагчдын дунд зохион байгуулсан. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 77 | 3.1.4.6. Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, тэдгээрийн бүртгэл мэдээлэл, үнэлгээ тайланг ил тод, нээлттэй болгон өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлнэ. | Төрийн байгууллагууд | | Өмчийн зөвлөлийн үйл ажиллагаа, хөрөнгийн тооллого хийсэн тоогоор | Өмчийн зөвлөл 1 удаа хуралдаж 1 удаа тооллого зохион байгуулсан. | Дотоодын тооллогыг энэ онд 2 удаа хийсэн тооллогын комиссын тайлан,тэмдэглэл бичиж баталгаажуулан архивласан. Хагас жилээр дотоодын тооллогыг зохион байгуулсан. Эд хөрөнгийг коджуулсан.Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг ажилтан бүртэй хийсэн. Нийт 11 барилгатай. Барилгын хувийн хэргийг хөтлөлт баяжилтийг сайжруулах тоног төхөөрөмж бүрт техник ашиглалтын паспорт байхгүйг шинээр нээж хөтөлсөн. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 11-р сарын 28 ны өдрийн 09/01 дугаартай тогтоолоор 178 төрлийн 94,699,553.14 төгрөгний тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, прогамм хангамж, компьютер түүний дагалдах хэрэгсэл зэргийг актласан. Дахин үнэлгээний Нийт 43 төрлийн 298,184,902.02 төгрөгний хөрөнгийг дахин үнэлгээнд оруулсан. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 24/02 дугаар тогтоолын захирамжийн 6ш King150-cc Мотоцикль 1 бүрийн үнэ 2,910,000 Нийт 17,460,000 төгрөгний хөрөнгийг бүртгэлд тусгасан. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06 сарын 27-ны өдрийн 07/08 дугаар тогтоолын Туяа багийн ЕБС-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 9 төрлийн 82,705,339.28 төгрөгний балансд шилжүүлэж хөрөнгийг бүртгэлд тусгасан.<br>Прогаммд хөрөнгийн бүртгэлийн ангилал зөв засаж бүртгэсэн.Элэгдэл | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тооцсон дахин үнэлгээ хийсэн.0 үлдэгдэлтэй хөрөнгийг шийдвэрлсэн. Тухайн жилд орон нутгийн өмчийн эд хөрөнгийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, судалгаа, мэдээ тайлан гаргах ажлыг зохион байгуулсан, цаг хугацаанд нь тайлагнасан. | | |
| **Хэсгийн дундаж үнэлгээ:100%**<br>**Хжсгийн дундаж үнэлгээ: 100%** | | | | | | | | |
| **3.2. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ** | | | | | | | | |
| **3.2.1.Мал сүргийг эдийн засгийн эргэлтэд оруулна.** | | | | | | | | |
| 78 | 3.2.1.3. Малыг эдийн засгийн эргэлтэд оруулан тоо толгойгоос чанарт шилжүүлэх бодлого хэрэгжүүлнэ. | ЗДТГ | | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоогоор | 0 | Өвөрхангай аймгийн хүн амын өвөл, хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулсан махны хангамжийн тогтвортой байдлыг хангах, орон нутгийн малчид, хоршоологчдын мал, бэлтгэсэн махыг шууд худалдаанд оруулж, хэрэглэгчдэд хүргэх зорилгоор зохион байгуулагдсан "Өвлийн идэш-2025" үйл ажиллагаанд 15 малчин өрх 600 гаруй тоо толгой малаа бэлтгэн оролцуулсан.<br>Сумын нийт малын тоо толгой: 411,902<br>Тэмээ- 103<br>Адуу- 29156<br>Үхэр- 17725<br>Хонь- 228427<br>Ямаа- 136491<br>Үүнээс эдийн засгийн эргэлтэд оруулах малын тоо: 80,652<br>Тэмээ- 8<br>Адуу- 4082<br>Үхэр- 2659 | 90 | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хонь- 47970<br>Ямаа- 25933<br>Эдийн засгийн эргэлтэд оруулсан малын тоо: 79,150<br>Тэмээ- 5<br>Адуу- 2702<br>Үхэр- 1700<br>Хонь- 34441<br>Ямаа- 40302 буюу 98,1%-ийн гүйцэтгэлтэй байна. | | |
| 79 | 3.2.1.4. Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжийг байгуулж, цөм сүргийн болон хээлтүүлэгч малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэн, мал сүргийг даатгалд хамруулах ажлыг зохион байгуулна. | ЗДТГ | | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоогоор | 0 | Мал үржүүлэг, үйлчилгээний нэгж суманд байхгүй.<br>Сумын хэмжээнд 1724 хээлтүүлэгч бүртгэлжүүлснээс хуц 948, ухна 776 байна. Үүнээс ялган төвлөрүүлсэн 537 хуц 341 ухна байна. Суманд хуц ухна дангаараа хариулдаг малчин байхгүй байна.<br>2024 онд 1071 өрх мал тоолуулсан. үүнээс мэдээллийн санд бүртгэгдсэн 1037 өрхийн мэдээллийг статистик мэдээлэлтэй тулган баяжилт шинэчлэлтийг 100% хийж гүйцэтгэсэн. хийж гүйцэтгэв. Шинээр мал тоолуулсан 32 малчны мэдээллийг шинээр бүртгэж праграммд оруулсан. Бусад аймаг сумдаас шилжиж ирсэн 45 малчин өрхийн мэдээлэл мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээгээр шилжиж ирэх тул хүлээгдэж байна. Мөн нас барсан болон 2024 онд мал тоолуулаагүй 33 малчины мэдээллийг идэвхигүй төлөвт оруулж баяжилтыг хийж байна.<br>2023 оны жилийн эцсээр мэдээллийн санд бүртгэлтэй 863 өрх байсан бол | 90 | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | энэ онд 1037 өрхийн мэдээлэл бүртгэж өмнөх оноос 174 өрхөөр нэмэгдүүлж баяжилтыг хийлээ. Мөн төл бойжилт мал төллөлт, том мал зүй бус хоргодолын мэдээг 7 хоног бүр мэдээллийн санд оруулж баяжилтыг тухай бүр хийж байна.<br>2025 онд шинээр малаа даатгалд хамруулсан малчдын тоо 26 , нийт даатгалд хамрагдсан малын тоо 3471, нийт мөнгөн дүн 4,302,000 төгрөг байна. | | |
| 80 | 3.2.1.7. Залуу малчдыг дэмжих бодлогыг хэрэгжүүлж, малчдыг чадавхжуулна. | ЗДТГ | 37,4 | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоогоор | 0 | Энэ онд малжуулахын төсөлд нэг өрхийн 2 залуу малчин хамрагдсан. 8.000.000 төгрөгний мал худалдан авсан. Орон нутгийн хөгжлийн сангаас Туяа багт 29.400.000 төгрөгөөр нийт 40 малчин өрхөд гар худгийн онгоц засварлах асуудлыг шийдэж өгсөн. | 100 | 100 |
| 81 | 3.2.1.8. Суманд мах,сүүний чиглэлийн жижиг цэх ашиглантанд оруулан малаас гарах бүтээгдэхүүний эдийн засгийн үр нөлөөг нэмэдүүлнэ. | ЗДТГ | | Мах, сүүний цехийн тоогоор | 0 | Хугацаа болоогүй | - | - |
| **3.2.2.Бэлчээр ашиглалт, малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |
| 82 | 3.2.2.1. Малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ. | ЗДТГ | | Тариалалтыг нэмэгдүүлсэн байдлаар | Хүрэмтийн услалтын систем үерт автаж тариалалт буурсан. | Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах тухай Аймгийн Засаг даргын 2025.09.03 -ны өдрийн А/553 дугаар захирамжийн хавсралтаар сумын аюулгүй нөөцөд өвс 122.4 тонн, тэжээл 106.1 тонн бэлтгэвэл зохих төлөвлөгөөний дагуу өвс 27,5 тонн, | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хивэг 8.7 тонн, овьёос 12,5 тонн, ногоон тэжээл 3 тонн үлдэгдэлтэй байсан. Нэмэлтээр 5 тонн өвс худалдан авч сумын аюулгүй нөөцийг бүрдүүлсэн. Энэ онд малчдын түвшинд бэлтгэсэн өвс, тэжээлийн нөөцийн мэдээг багийн дарга нараас албан тоот, хүснэгтийн дагуу авч сумын хэмжээнд нэгтгэн аймгийн ХХААГазарт 7 хоног бүр хүргүүлж байна. 2025 оны 10 сарын 13 -ний байдлаар өвс- 500 тн, ногоон тэжээл 250 тонн, гар тэжээл -350 тонн, давс, хужир, шүү 180 тонн бэлтгэвэл зохих төлөвлөгөөнөөс өвс 415 тонн, сүрэл 36 тонн, ногоон тэжээл 145 тонн, үйлдвэрийн тэжээл – 98 тонн, гар тэжээл -81 тонн, давс, хужир, шүү 37 тонн зэрэг бэлтгэсэн байна. Биелэлт: Нийт 1280 тонн хадлан бэлтгэхээс 826 тонныг биелэлттэй 64.5 хувьтай байна. | | |
| 83 | 3.2.2.2. Бэлчээрийг усжуулах, сэлгэж өнжөөх, хортон мэрэгчдээс хамгаалах зэргээр ашиглалтыг сайжруулна. | ЗДТГ | 36,4 | Авсан арга хэмжээний тоогоор | 0 | Туяа багийн 40 өрхөд гар худгийн онгоцыг шинэчилсэн. Оготно устгалын ажил 2,3,5-р багийн нутаг дэвсгэрт хэсэгчилсэн байдлаар хийгдсэн. | 100 | 100 |
| 84 | 3.2.3 Хөдөө аж ахуйн малчдын хоршоог чадавхижуулна | ЗДТГ | | | Шинэ хоршоо үндэсний хөдөлгөөний хүрээнд 47 хоршоо байгуулагдсан. | Малчид хоршооны үйл ажиллагаанд итгэх итгэл нэмэгдэж, "Шинэ-Хоршоо" хөдөлгөөнд шинээр 23 өрх нэгдсэн. Тус шинээр байгуулагдсан хоршоодын нарийвчилсан судалгааг гарган мэдээллийн бааз үүсгэсэн. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хоршооны нийт гишүүдийн тоо 430-аар нэмэгдсэн. Шинэ хоршоодын мал аж ахуй, түүхий эд боловсруулах чиглэлээр ихэнх хувийг эзэлж байна. 47 шинэ хоршоонд хоршоо үүсгэн байгуулах тухай хурлын талаарх мэдээллийг хүргэж 5 хоршооны үүсгэн байгуулах бүх гишүүдийн хуралд биечлэн оролцсон.<br>Хоршооны санхүүгийн үйл ажиллагааг хэрхэн бүртгэх талаар зааварчилгаа өгсөн. Хоршооны татварын хууль, боломжит хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар мэдээлэл өгсөн.<br>"Хоршооны тухай" хуулийн 2 видео танилцуулга, 2 төрлийн гарын авлагыг бэлтгэн цахимд байршуулсан.<br>Хаан банканд 7 хоршооны 15 малчин 465.0 сая.төгрөг, Төрийн банканд 13 хоршооны 45 малчин 1,710.0 сая.төгрөгийн зээлийн мал худалдан авах, байр саравч барих, сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлийн төслийн зээл авсан. Батлан даалтын сангаас Хаан банкаар зээл авсан 3 хоршооны 8 малчин 137.05 сая.төгрөг, Төрийн банкнаас 8 хоршооны 620.14 сая.төгрөгийн батлан даалтын санхүүжилт авсан.<br>Олон улсын Хоршооллын өдөрт 1 жишиг хоршоог үзэсгэлэн худалдаанд оролцуулж туршлага судлуулав. Тус үзэсгэлэнгийн үеэр 400.00 мянган төгрөгийн борлуулалт хийгдсэн байна. | | |
| **3.2.4.Мал эмнэлгийн оношилгоо, шинжилгээний түвшинг нэмэгдүүлж, мал, амьтны гоц халдварт, халдварт, өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, халдваргүй өвчний өвчлөлийг бууруулна.** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
